



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024 04.25 № 1072
танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Монгол Консерватив нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож, дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Монгол Консерватив нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Монгол Консерватив нам"-ын мөрийн хөтөлбөр /..... 43хуудас-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030710



МОНГОЛ КОНСЕРВАТИВ НАМ

МОНГОЛ КОНСЕРВАТИВ НАМЫН 2024 ОНЫ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
“ТӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ-13С”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ATA9693 9006109
9023030583

Энэхүү мөрийн хөтөлбөр нь 4 жилд Монгол улсыг засах мөрийн хөтөлбөр бөгөөд “Хөх Эрдмийн Монгол 44” Монгол улсыг 44 жилд хөгжүүлэх хөгжлийн цогц бодлогын бүрэлдэхүүн хэсэг болно.

Улаанбаатар хот
2024 он


900000001¹

Мөрийн хөтөлбөрт тайлбар


Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тогтвортой засаглал мөн. Тогтвортой засаглалыг хангах нь Монгол улсын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын үзэл баримтлал, батлан хамгаалах номлолын дагуу улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино.

Уг мөрийн хөтөлбөр нь Монгол улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйл, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг удиртгал болгосон. Мөн Монгол улсын Үндэсний нийт бүтээгдэхүүн, Дотоодын нийт бүтээгдэхүүн, Монгол улсын 2025, 2026, 2027, 2028 оны төсвийн төсөөллийн хүрээнд боловсруулсан болно. Монгол улсын Улсын их хурлын "Алсын хараа-2050" монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 тоот тогтоолыг үндэслэсэн болно. Боловсруулахдаа дараах зарчимд суурилсан болно.

Үүнд:

- ✓ Үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- ✓ Нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- ✓ Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
- ✓ Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- ✓ Нөөц бололцоонд тулгуурласан байх;
- ✓ Ил тод, нээлттэй байх;
- ✓ Олон нийтийн оролцоог хангасан байх зэрэг болно.



Handwritten signature in blue ink and a red stamp with the number 00000002.

АГУУЛГА

ТҮМЭН ОЛОНД ӨРГӨХ БОСГО ҮГ

1. "ХӨХ ЭРДМИЙН МОНГОЛ-7С" ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА
 - 1.1. "САРУУЛ МОНГОЛ" ОЮУН САНААНЫ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
 - 1.1.1.МОНГОЛЫН ЯЗГУУРЫН ҮНЭТ ЗҮЙЛ
 - 1.1.2.ГЕОПОЛИТИКЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.1.3.ТУСГААР ТОГТНОЛД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.1.4.ЯЗГУУРИЙН ТӨРТ ЁСНЫ САНАМЖИТ ГЭРЭЭСЛЭЛ
 - 1.1.5.МОНГОЛ ХЭЛЭЭ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.1.6.ҮНДЭСНИЙ АШИГ СОНИРХОЛЫН ЭРЭМБЭНИЙ ШИНЭЧЛЭЛ
 - 1.2. "САХИЛГАТАЙ МОНГОЛ" УЛС ТӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
 - 1.2.1.МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ ЗАСАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.2.2.УЛСЫН ИХ ХУРЛЫГ ЗАСАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.2.3.ЗАСГИЙН ГАЗРЫГ ЗАСАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.2.4.817 ХУУЛИЙН ЗАСАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.2.5.ТӨРИЙН "ХАР" ХҮНИЙГ БЭЛТГЭХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.2.6.ЁС СУРТАХУУНТ ИРГЭНИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.3. "САН ХӨМРӨГТЭЙ МОНГОЛ" ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
 - 1.3.1.ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.3.2.АЛДАЛГҮЙ, ХЯНАЛТТАЙ ТӨСВИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.3.3.БАГА ТАТВАРЫН ТОГТОЛЦОО БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.3.4.БАЯЛАГЫГ УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.3.5.САНГУУДЫН УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.3.6.ХУВИЙН ӨМЧИЙГ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.4. "СЭТГЭЛТЭЙ МОНГОЛ" НИЙГМИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
 - 1.4.1.ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.4.2.ХАЛАМЖИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.4.3.ӨВ, СОЁЛЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.4.4.ДЭД БҮТЦИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.4.5.БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.4.6.АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.5. "СҮЙХЭЭТЭЙ МОНГОЛ" ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.5.1.ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.5.2.ГАДААДЫН ЭЛЧИН, ТӨЛӨӨЛӨГЧИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.5.3.БАТЛАХ ХАМГААЛАХ, АЮУЛААС ХАМГААЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.5.4.ХЯТАД УЛСТАЙ ХАРИЛЦАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.5.5.ОРОС УЛСТАЙ ХАРИЛЦАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.5.6.БУСАД УЛСТАЙ ХАРИЛЦАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ
 - 1.6. "СҮЛДТЭЙ МОНГОЛ" БИЛИГ ЭРДМИЙН ХУВЬСГАЛ
 - 1.6.1.ГАЛ ДҮРСЛЭЛ
 - 1.6.2.НАР, САРАН ДҮРСЛЭЛ
 - 1.6.3.ДӨРВӨН ТӨРИЙН НЭГДСЭН ХҮЧНИЙ ТЭМДЭГТ
 - 1.6.4.ТЭНГЭР, ГАЗРЫН СУДРЫН ТЭМДЭГТ
 - 1.6.5.АРГА БИЛИГ ДҮРСЛЭЛИЙН НУУЦ
 - 1.6.6.УДМУУДЫН ТЭМДЭШТ БАГАНА ДҮРСЛЭЛ
 - 1.7. "СЭРСЭН МОНГОЛ" УХАМСАР СЭРЭЛТИЙН ХУВЬСГАЛ
 - 1.7.1.ХӨХ ОРШИХУЙ
 - 1.7.2.ХӨХ ТӨР
 - 1.7.3.ХӨХ ТОЛБО
 - 1.7.4.ХӨХ СУДАЛ
 - 1.7.5.ӨНГӨТ СҮЛД
 - 1.7.6.АЛТАН ТУГ
 - 1.8. СӨРСӨН МОНГОЛ ШУДАРГУУН ЁСНЫ ХУВЬСГАЛ

- 1.8.1.АВЛИГАЧДААС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
- 1.8.2.АРХИНААС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
- 1.8.3.АНАРХИСТУУДААС САЛАХ БОДЛОЫГН ХУВЬСГАЛ
- 1.8.4.АЖИЛГҮЙДЛЭЭС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
- 1.8.5.АБОРТЫГ ТАСЛАН ЗОГСООХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
- 1.8.6.АЛСЫН УДИРДЛАГААС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
- 1.8.7.АМИНЧ ҮЗЛЭЭС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
- 1.9. СУУЦТАЙ МОНГОЛ АХУЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
 - 1.9.1.ХОТУУДЫН ДЭД БҮТЭЦИЙН СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ
 - 1.9.2.ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН БОДЛОГЫН ӨӨРЛӨЛТ
 - 1.9.3.УЛАМЖЛАЛТ ГЭРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГО
 - 1.9.4.СУУЦТАЙ ЗАЛУУ ГЭР БҮЛ ТӨРИЙН БОДЛОГО
 - 1.9.5.АХУЙН ШИНЭ (МИНИМАЛИСТ) ХЭВ ЗАГВАРЫН ХУВЬСАЛЫН БОДЛОГО
 - 1.9.6.СУУЦТАЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТӨРИЙН БОДЛОГО
- 1.10. СЭРЭМЖТЭЙ МОНГОЛ ҮНДЭСНИЙ СОРИЛТЫГ ЖАМЫН ХУВЬСАЛ
 - 1.10.1. БАЙГАЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ УСНЫ АЮУЛЫГ ДАВАХ БОДЛОГО
 - 1.10.2. БАЙГАЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ ГАЗАР ХӨДЛӨЛТ, ГАЛЫН АЮУЛЫГ ДАВАХ БОДЛОГО
 - 1.10.3. БАЙГАЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ ЗУД, ШУУРГЫН АЮУЛЫГ ДАВАХ БОДЛОГО
 - 1.10.4. ДОТООД БИЛГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ СЭТГЭЛИЙН СОРИЛТЫГ ДАВАХ БОДЛОГО
 - 1.10.5. ДОТООД БИЛГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ УХАМСАРЫН СОРИЛТЫГ ДАВАХ БОДЛОГО
 - 1.10.6. БОДЬГАЛ БИЕТ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ДАВАХ БОДЛОГО
- 1.11. СУРТАХУУНТАЙ МОНГОЛ ТӨЛӨВШИЛИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
 - 1.11.1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХДИЙН ТӨЛӨВШИЛИЙН БОДЛОГО
 - 1.11.2. ЕРӨНХИЙ БОЛОСРОЛЫН СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХЭД ТӨЛӨВШҮҮЛЭХ БОДЛОГО
 - 1.11.3. ЗАЛУУЧУУДУУДЫГ ӨӨРИЙГ УДИРДАН ЗАСАХУЙН ТӨЛӨВШИЛИЙН БОДЛОГО
 - 1.11.4. НИЙХЭМЭЭР АМЬДРАХ НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНЫ БОДЛОГО
 - 1.11.5. УХАМСАРЛАН ХӨГЖИХҮЙН ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ БОДЛОГО
 - 1.11.6. БИЛИГ ЭРДЭМД СУРАЛЦАХУЙН ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ХӨТӨЛБӨР
- 1.12. СҮРЭГТЭЙ МОНГОЛ НҮҮДЭЛЧДИЙН ӨВИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
 - 1.12.1. МАЛЧИД, ТАРИАЛАНЧДЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО
 - 1.12.2. НҮҮДЭЛЧДИЙН ӨВ, СОЁЛ ХАМГААЛАХ БОДЛОГО
 - 1.12.3. ТАВАН ХОШУУ МАЛЫН ХҮНС, ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ
 - 1.12.4. МАЛЧДЫН ХОРШИЛТЫГ ДЭМЖИХ БОДЛОГО
 - 1.12.5. ХОСОЛСОН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
 - 1.12.6. ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУЛГУУРЛАСАН ҮЙЛДВЭРҮҮДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО
- 1.13. СУУТ МОНГОЛ ЯЗГУУР ХААДЫН ТӨРИЙН ЗАРЛИГУУДААС
 - 1.13.1. ДУВА МЭРГЭН ТЭНГЭРИЙН ХААНЫ ЗАРЛИГААС
 - 1.13.2. ДОБУ МЭРГЭН ТЭНГЭРИЙН ХААНЫ ЗАРЛИГААС
 - 1.13.3. ХҮННҮ ГҮРНИЙ ИХ ШАНЬЮ ТҮМЭН ШАНЬЮГИЙН ЗАРЛИГААС
 - 1.13.4. СЯНЬБИ ГҮРНИЙ ИХ ХААН ТАНШИХУЙ ХААНЫ ЗАРЛИГААС
 - 1.13.5. ИХ НИРУН ГҮРНИЙ ХААН МУГУЛҮЙ ХААНЫ ЗАРЛИГААС
 - 1.13.6. ХӨХ ТҮРЭГ ГҮРНИЙ ХААН БУМАН ХААНЫ ЗАРЛИГААС
 - 1.13.7. УЙГАРЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ХААН КУТЛУК БИЛГЭ КУЛ ХААНЫ ЗАРЛИГААС
 - 1.13.8. ИХ МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ХААН ЧИНГИМ ХААНЫ ЗАРЛИГААС
- 1.14. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД
 - 1.14.1. ЯЗГУУРЫН ТӨРИЙН БОДЛОГО БАРИМТЛАГЧ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
 - 1.14.2. ЯЗГУУРЫН ТӨРИЙН БОДЛОГО БАРИМТЛАГЧ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ,
 - 1.14.3. ЯЗГУУРЫН ТӨРИЙН БОДЛОГО БАРИМТЛАГЧ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
 - 1.14.4. ЯЗГУУРЫН ТӨРИЙН БОДЛОГО БАРИМТЛАГЧ МОНГОЛ КОНСЕРВАТИВ НАМ
 - 1.14.5. ЯЗГУУРЫН ТӨРИЙН БОДЛОГО БАРИМТЛАГЧ САРУУЛ УХААНТАНУУД
 - 1.14.6. ЯЗГУУРЫН ТӨРИЙН БОДЛОГО БАРИМТЛАГЧ ЁС СУРТАХУУНТАЙ ИРГЭН БҮР

ТУНГААН УНШСАН ТАНД ӨРГӨХ ТОТГО ҮГ

ТҮМЭН ОЛОНД ӨРГӨХ БОСГО ҮГ

Өнө эртний өвөг дээдсийн язгуурын төрт ёсны эрдмийг тунгаан нягтлаж, бошиг өндөр хаадын айлдвар, сургаалийг ишлэн татаж, энэ цагийн судлаачдын судалгааг нэгтгэж найруулж, Тэнгэрийн санааг зарчимлан, шинжлэх ухаанчаар хандан Монгол улсаа засан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон боловсруулсан “ТӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ- 13С” мөрийн хөтөлбөрөө Монгол орон даяар тунхаглан түгээж байна.

Оюу билигт төрийг байгуулна.

Оюу билигтнээр удирдуулсан төр
Язгуурын төрт ёсоо дээдлэгч төр
Шударга ёсыг эрхэмлэгч төр
Монгол хүнийг нэгдүгээрт тавигч төр
Цомхон бүтэцтэй төр
Зарлиг, шийдвэр хүчтэй төр
Ёс суртахуунтай төр
Иргэнээ асран тэтгэсэн төр
Хувийн өмчийг хамгаалсан төр
Улс данмасан бодлого хэрэгжүүлэгч төр
Хараат бус бодлоготой төр
Нэгдсэн цогц бодлоготой төр
Нэгдмэл удирдлагатай төр
Дэлхийн энх тайваныг дэмжигч төр
Хүнээ төлөвшүүлэн, хөгжүүлэгч төр
Удам сайт төрийн түшээдтэй төр
Төсөв нээлттэй, хяналттай төр
Хүнд сурталгүй, цахим төр
Эдийн засгийн баталгааг бүрдүүлэгч
Шуналтан үгүй эрх мэдэлтэнтэй төр байгуулна.

Монгол Консерватив намын дарга

Хүрэн зээрд удамт Намжилын Дашдаваа

“ТӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ 13С” МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

1. “СARУУЛ МОНГОЛ” ЯЗГУУРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

I үе шат (2021-2030): Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе. 1.Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзэл, үндэсний эв нэгдэл сэргэнэ. 2.Өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч монгол хүнийг төлөвшүүлнэ. 3.Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд үндэсний онцлог, соёлын хүрээг өргөжүүлнэ. 4.Түүх, соёлын дурсгал, урлагийн бүтээл, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээж, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, өвлүүлж хэвшинэ. 5.Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байна.

I үе шат (2021-2030): Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох үе. 1.Экосистемийн үнэ цэн экологийн даацыг тогтоож, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ. 2.Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бохирдол үүсгэгчийг багасгаж, агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулсан байна. 3.Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангаж, гадаргын усыг хуримтлуулан, дахин ашиглаж, усны үнэ цэнийг нэмэгдүүлнэ. 4.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болсон байна. 5.Хотын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг боломжит бүх байршилд нэмэгдүүлж, хот доторх оршуулгын газрыг дахин зохион байгуулна. 6.Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах, гамшгийг эрт илрүүлэх, тэсвэрлэн гарах чадавхыг бэхжүүлнэ. 7.Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно. 8.Агаар, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг олон улсын түвшинд хүргэнэ. 9.Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ. Алсын хараа-2050 хөтөлбөрт нийцүүлэн боловсруулав.

1.1. МОНГОЛЫН ЯЗГУУРЫН ҮНЭТ ЗҮЙЛ

Үнэт зүйлээ умартан, бусдын үнэт зүйл төөрөлдөн буй байдлыг эцэс болгоно. Бидний үнэт зүйл бол бидний язгуурын үнэт зүйл. Харийн үнэт зүйл бидний үнэт зүйл байх ёсгүй. Монголчуудын язгуурын үнэт зүйлүүдийг Монгол улсын Үндсэн хуульд заямал үнэт зүйл хэмээн тодорхойлон оруулж Монгол хүр бүр эрхэмлэн дээдлэхийг иргэний үүрэг оруулна.

1. Монгол үндэстэн
2. Монгол хүний язгуурын эрдэм
3. Монгол хэл
4. Тусгаар тогтнол
5. Язгуурын төрт ёсны хөх бодлого
6. Түүхийн санамжит гэрээслэл
7. Төрөлхийн тэнгэрлэг байдал
8. Монголын газар шороо
9. Дэлхийг төвшитгөсөн их дуулал
10. Ахан дүүсэг андын харилцаа
11. Монгол хүний мөн чанар
12. Удмын үнэт зүйлс
13. Ардчиллын үнэ зүйлс бидний үнэт зүйл
- Чөлөөт байдал

- Хүний эрх, үүрэг
- Шударга ёс
- Эв нэгдэл
- Тэнцүү байдал
- Хувийн өмч
- Иргэний нийгэм
- Иргэдийн оролцоо
- Хамтын зах зээл
- Хуулийн засаглал
- Улс төрийн зөвшилцөл
- Чөлөөтэй сонгууль

1.2. ГОЕПОЛИТИКЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Жалга довоор хуваагдаж, улам жижигрэх хүсэл, нам, нутаг улс гэж хуваагдах байдлыг зөвшөөрөхгүй. Аймаг, сум гэх мэт Монгол хүнийг тарааж бутаргах, хэрэлдүүлж талцуулах гэсэн атгаг бодлогыг эцэслэнэ. Ард түмнийг түгжрэлд цагийг үрдэг, аливаа төрлийн хязгаарлалт тогтоож, хэт төвлөрөл явуулж тав тухтай амьдрах эрхийг хязгаарлаж, хаана ч амьдрах эрхийг үгүйсгэх хандлагыг өөрчилнэ.

Дэлхийн хүчирхэг үндэстнүүд өөр өөрийн гэсэн гоеполитикийн газрын зургийг гаргаж түүнийгээ улс төр, эдийн засгийн хөгжлийн шинэ хандлагад ашиглаж байна. Тиймээс бид ч гэсэн байрлалын давуу талыг ашиглан өөрийн гэсэн улс төр, эдийн засгийн гоеполитикийн газрын зургийг гаргаж амбицаа илэрхийлнэ. Монгол төвт гоеполитикийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Орхоны хөндийд байрлах төвийн бүсийн хот, Говийн бүсийн хөгжлийн хот, Баруун бүсийн хөгжлийн хот, Хангайн бүсийн хөгжлийн хот, Зүүн бүсийн хөгжлийн хот гэсэн 5 бүсэд хотуудыг байгуулна.

Монгол улсын нийслэлийг Орхоны хөндийд байгуулна. Монголын түүхийн хамгийн том дурсамжтай, санамжтай газар нийслэлээ байгуулах ба тэр нь Хархорин хот, Хархул хот, Луут хотууд байрлаж байсан Орхоны хөндий юм. Дэлхийн зах зээлд чиглэсэн гол удирдлагыг тодорхойлох төв хотыг төвийн бүсэд байгуулна. Монгол Улсын нийслэлийг Орхоны хөндийд байгуулж дэлхийн оюун санааны төв, улс төрийн төв, эдийн засгийн төв, шинжлэх ухааны төв болохоор зохион байгуулна. Төвийн бүсийн хотод Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн зарим сумдууд, Булган аймгийн зарим сумдууд, Төв аймгийн зарим сумдууд хамаарна.

Америк төвийн эдийн засгийн хөгжлийн бүс (Хойд Америк, Латин Америк, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос)-ийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх зорилготой мэдлэгт суурилсан хотыг зүүн бүсэд байгуулна. Зүүн бүсийн хөгжлийн хотод Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын газар нутаг, Дорноговь аймгийн зарим сумдууд хамаарна. Зүүн бүсийн хөгжлийн хот нь Америк тивийн эдийн засгийн хөгжилтэй шууд уялдуулж, судалгаа хөгжлийн төвүүдийг байгуулна.

Өмнөдийн эдийн засгийн хөгжлийн бүс (Хятад, Энэтхэг, Зүүн өмнөд Ази, Австрали, Шинэ Зеланд)-ийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх зорилготой мэдлэгт суурилсан хотыг говийн бүсэд байгуулна. Говийн бүсийн хөгжлийн хотод Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Баянхонгор аймгийн зарим сумдуудын нутаг хамаарна. Говийн бүсийн хөгжлийн хот нь Өмнөд зүгт хиллэх орнуудын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдуулж, судалгаа хөгжлийн төвүүдийг байгуулна.

Баруун өмнөд бүс (Төв Ази, Баруун өмнөд Ази, Африк тив)-ийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх зорилготой мэдлэг суурилсан хотыг баруун бүсэд байгуулна. Баруун бүсийн хөгжлийн хотод Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-

Алтай, Завхан аймгуудыг газар нутаг, Баянхонгор аймгийн зарим сумдууд хамаарна. Баруун бүсийн хөгжлийн хот нь Баруун зүгт хиллэх орнуудын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдуулж, судалгаа хөгжлийн төвүүдийг байгуулна.

Хойд бүс (Орос, Зүүн Европ, Баруун Европ)-ийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх зорилготой мэдлэгт суурилсан хотыг Хангайн бүсэд байгуулна. Хангайн бүсийн хөгжлийн хотод Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан Уул, Орхон аймгийн газар нутаг, Архангай зарим сум, Төв аймгийн зарим сумдууд хамаарна. Хангайн бүсийн хөгжлийн хот нь Орос, Европын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдуулж, судалгаа хөгжлийн төвүүдийг байгуулна.

Таван бүсэд орших улс орнуудын зах зээлийн судалгааг гаргаж, ирж яваа шинжлэх ухаан, технологийн 6, 7 дахь хувьсгалыг угтсан стратегийн дагуу, түүнд тохирсон дэд бүтэц бүхий орчин үеийн хотуудыг бүтээн босгоно. Бүсүүдэд сургууль, цэцэрлэг, их сургууль гээд цогцолбор хэлбэрээр байгуулах бөгөөд Монгол улсын иргэн идэх хоол, өмсөх хувцас, орон байраар бүрэн хангагдаж, сурч боловсрох, хөдөлмөрлөх бололцоог бүрэн нээж өгнө.

Орхоны хөндий мэт Монгол үндэстний түүхийн бахархал болсон архитектурын хайгуулын үндэстний стратегийн салбар болгон тодорхойлж, архитектурын олдвор дээр нь музейнууд байгуулж, даяарчилсан аялал жуулчлалын дагуул хот, соёлын аж үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор философи, утга зохиол, жүжгийн зохиол, кино аж үйлдвэр болон нийгмийн дэд бүтцийг хосолсон дагуул хотуудыг бүсийн хотуудад тулгуурлан байгуулж, хүн төрөлхтний оюуны амьдралыг авч явах Монгол үндэстний хүслээ хэрэгжүүлнэ.

Монгол улсын үндсэн хуулийн 2.2 дахь заалт, Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг өөрчлөн найруулна.

1.3.ТУСГААР ТОГТНОЛД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Орон зайн тусгаар тогтнолоо хамгаална. Монгол улсын хил хязгаарыг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хамгийн баруун захын цэг нь Монгол Алтайн нурууны өргөрөгийн 48 градус 53 минут, уртрагийн 87 градус 44 минутад орших 3,245.6 тоот Мааньт уул, зүүн захын цэг нь Соёлз уулын өргөрөгийн 46 градус 43 минут, уртрагийн 119 градус 56 минутад орших 1,290.0 Модотой хамар, хойт захын цэг нь Хөвсгөлийн Тэнгис голын өргөрөгийн 52 градус 09 минут, уртрагийн 98 градус 58 минутад орших Монгол Шарын даваа, өмнөд захын цэг нь өргөрөгийн 41 градус 35 минут, уртрагийн 105 градус 00 минутад орших Орвог гашууны Бор толгой хэмээн үзнэ. Монгол хүнийг тойрон хүрээлж орших энэ цэгүүдээс дотогш эх орон оршино. Хил цэсийн тухай хууль, газрын тухай хуулиар дамжуулан зах хязгаараас болон дотроос нь эзэмших санаархлыг таслан зогсоож Монголын төр хуулиар хамгаална. Бүтэн байлгах бол бидний үүрэг...

Ахуйн тусгаар тогтнолоо хамгаална. Уламжлалт нүүдлийн соёлыг хуульчлан хамгаална. Ахуйт эдийн засгийн даяарчилсан бодлогыг хэрэгжүүлж олон улсын хамтын ажиллагаа гадаад худалдааны хэлцээрийн дагуу хөгжүүлнэ. Торгоны зам лугаа эдийн засгийн босоо, болох хэвтээ тэнхлэгүүдийн коридориудыг байгуулна. Монгол хүний амьдралын эдийн засгийн суурь баталгааг хангах эдийн засгийн шинэ загвар боловсруулан хэрэгжүүлнэ.

Цусны тусгаар тогтнолоо хамгаална. Ураг, удмын тухай хуулийг батлаж язгуур удам тогтоох ажлыг орон даяар явуулж үндэсний мэдээллийн баазтай болно. Удам, цус хамгаалах бодлогыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлын анхааралд авна. Удам судрыг нягтлан гаргаж төрийн үйл хэрэгт тусгайлан зүтгүүлнэ. Гадаадын иргэнтэй гэр бүл болох асуудлыг төрийн анхааралд авна.

Тархины тусгаар тогтнолоо хамгаална. Монгол хүний төрөлхийн өгөгдөл, язгуур өндөр үүргийг ухамсарлуулах хөтөлбөрийг орон даяар хэрэгжүүлнэ. Тархины дархлааг

хамгаалахын тулд уламжлалт хүмүүжлийн аргуудыг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сургуулийн хөтөлбөрт суулгана. Монголын язгуурын боловсролын хөтөлбөрийг боловсруулагч өв тээгч нартай хамтран ажиллана.

Засгийн тусгаар тогтнолоо хамгаална. Засаглалын бодлогод гадаадын байгууллагууд ил далдаар нөлөөлөхийг таслан зогсооно. Монголчууд төрөө өөрөө хараат бусаар жолоодох эрх зүйн орчинг төгөлдөрүүлнэ. УИХ, Засгийн газрын шийдвэрт гадаадын бодлогыг оруулж нөлөөлдөг албан тушаалтанг эх орноосоо урвасан хэмээн үзэж шүүнэ. Эдийн засгийн ашиг сонирхолоор хууль баталдаг тогтолцоог хална.

Эрдмийн тусгаар тогтнолоо хамгаална. Монгол хүн бүр өөрийн удам өвгөдийн эрдэм мэдлэгийг биедээ тээн төрдөг гэдгийг бид ойлгох ёстой. Эрдэм мэдлэг тээж төрсөн хүн бүр Монгол улсын эрдэм мэдлэгийг мэдээллийн сан юм. Тиймээс Монгол хүн бүрийг онцгой үүрэг тээж төрсөн гэж үзнэ. Тэр эрдэм мэдлэгүүдийг өөрийгөө нээж олох замаар дэлгэрүүлэн төр болон түмний төлөө зориулах ёстой. Монголын язгуурын эрдмийг хамгаалахын тулд Монгол хүнийг хамгаална. Монгол улсын Үндсэн хуулинд “Монгол хүн төрийн хамгаалалтанд байна.” гэсэн заалтыг оруулна.

1.4 ЯЗГУУРЫН ТӨРТ ЁСНЫ САНАМЖИТ ГЭРЭЭСЛЭЛИЙГ БҮҮ МАРТ

Язгуурын төрт ёсны их хаад, улс төр, нийгмийн зүтгэлтэнүүдийн ирээдүй хойч үедээ санамж болгож үлдээсэн зарлиг, сургаал, хэлсэн үгийг бид чанадлан мөрдөх учиртай. Эрт цагийн хаадын зарлиг, улс төрийн зүтгэлтнүүдийг үгс одоо болтол амин чанараа тээсээр буй бид ойлгох ёстой.

“Газар бол улсын үндэс мөн.” Хүннү гүрний их Шанью Модун. “Алд бие минь алжааваас алжаатугай. Ахуй төр минь бүү алдартугай. Олон улсыг барья гэвэл биеийг нь сэтгэлийг нь хураагтун.” Их Монголын эзэнт гүрний хаан Чингис хаан “Мэндлэн хүндлэх аваам чөтгөр ч ирсэн мэхий. Миний нутгийн газар шорооноо бурхан гуйсан бүү өг.” Зүүн гарын хаант улсын хаан Галдан бошигт. “Үндсээ үл мэдэх нь адгуус буюу. Өвөг юугаан үл мэдэх нь мал буюу. Нүд бий бөгөөтөл түүх юугаа үл мэдэх нь сохор номин буюу. Мэдэлтэй бөгөөтөл язгуур юугаа үл мэдэх нь мунхаг гахай буюу. Ванчинбалын Инжинаш. “Эрхэмлэж яваарай хэмээн машид итгэн эрх чөлөө, тусгаар тогтнолыг үлдээв.” Маршал Хорлоогийн Чойбалсан. “Жанчхүүгийн даваанаас нааш Хятад шаахайн мөр бүү гарга.” Чин Ван Хандорж. “Миний цэрэг гэр гэртээ байгаа. Монголын төлөө цохилох зүрхтэй хүн бүр Монгол төрийн туган дор надтай хамт жагсах цэрэг...” Хатанбаатар Магсаржав.

“Чихний чимэг болсон аялгуу сайхан Монгол хэл

Чин зоригт өвөг дээдэсийн минь өв их эрдэнэ

Сонсох бүр яруу баялагыг гайхан баясаж

Сод их билэгт түмэн юүгээн бишрэн магтмуу Би.” Еншөөбү Бямбын Ренчин

“Монгол хүний саруул ухаан би итгэдэг.” Санжаасүрэнгийн Зориг

“Ташуураар хамгаалсан эх орноо тархиараа хамгаалах цаг ирлээ.” Лодонгинь Түдэв

“Газар бол таны үндсэн хөрөнгө, газраа гадаадынханд барьцаалах, түрээслэх, өмчлүүлэх, худалдах нүгэл үйлдвэл иргэн та гишгэх газаргүй хөл болно. Эх орон минь шархадлаа. Энэ шархыг амь нас, эр зориг, оюун ухаан, авъяас билгээрээ нөхөх хөвгүүд нь хаа байна? Очирбатын Дашбалбар

“Төр ямар бодлого явуулна, түүнээс улс орны хувь заяа хамаардаг.” Дашийн Бямбасүрэн\

“Хонгилыг үзүүрт гэрэл гарлаа.” Пунцагын Жасрай

1.5. МОНГОЛ ХЭЛЭЭ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Монгол хэлний тухай хуулийн 7.2 дахь заалт “Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохин бэлтгэлийг хангасны үндэсэн дээр төрийн болонорон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.” гэсэн заалт 2025 оноос дагаж мөрдөгдөнө. Монголын язгуурын хэлийг хэрэглэх нь Монгол хүний эрдэм мэдлэг, сэтгэхүй Монголоороо хадаглагдан хамгаалагдах чухал юм. Монгол хэлний тухай хууль болох боловсролын тухай хуулинд 12 нас хүртэл Монгол хэл заана гэсэн заалтыг хуульчлан оруулна. Монгол хэл доторхи аялгуу тухай хэлний дархлагааг хамгаалдаг тул Монгол хэлний үнэ цэнэ үнэлэмжийг нэмэгдүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлнэ.

1.6. ҮНДЭСНИЙ ЯЗГУУР АШИГ СОНИРХОЛ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Үндэсний язгуурын ашиг сонирхолыг байранд нь тавиж, хамгаалах бодлого явуулна. Үндэсний язгуур ашиг сонирхол ямагт нэгд байх ёстой. Түүнээс дээгүүр хүний ашиг сонирхол, бүлгийн ашиг сонирхол байх ёсгүй.

“Монгол улсын язгуур ашиг сонирхолд Монгол улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана.” эдгээр ашиг сонирхол бүрэн хангагдаж буй талаар судалгаа шинжилгээ хийх шаардлагатай.

Үндэсний язгуур ашиг сонирхолын өмнүүр хувь хүн, бүлэглэл, улс төрийн нам, олон улсын байгууллага орохгүй байх хамгаалах бодлого хэрэгжүүлнэ. Монгол улсын үндсэн хуулинд “Монгол улс үндсэн хуулиндаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.” гэснийг “Монгол улс үндсэн хуулиндаа харшилсан , үндэсний язгуур ашиг сонирхолд харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.” гэж өөрчлөн оруулах.

2. “САХИЛГАТАЙ МОНГОЛ” УЛС ТӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

I үе шат (2021-2030): Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх үе. 1.Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байна. 2.Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, залгамж чанартай, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ. 3.Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө. 4.Улс төрийн намуудыг улс орныхоо төлөө бодлогын нам болгох нийгэм, улс төрийн соёлыг төлөвшүүлнэ. 5.Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдэж, иргэдийн улс төрийн боловсрол дээшлэн, иргэд, сонгогчдын хариуцлага сайжирна. Алсын хараа-2050 хөтөлбөрт нийцүүлэн боловсруулав.

2.1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ ЗАСАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Монгол улсын Үндсэн хуулийг язгуурын төрт ёсны тухай хууль, цаазуудын судалгаанд тулгуурлан засна.

Монгол улсын Үндсэн хуулинд дараахь заалтуудыг хуульчлан оруулна. Монгол улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйл, 5 дугаар зүйл, 6 дугаар зүйл, 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйл, 22 дугаар зүйл, 23 дугаар зүйл, 24 дүгээр зүйл, 25 дугаар зүйлүүдийг доорх байдлаар өөрчлөн найруулна.

...Монгол хүн Монгол төрийн хамгаалалтанд байна. ...Монгол орон даяар нэгэн тойрог тогтолцоогоор сонгуулиа явуулна. ...Сонгууль нь олон шатлалттай явагдана. ...Улсын удирдах дээд байгууллага нь Улсын дээд хуралдай байна. ...Түүний суудлын тоо 1728 байна. ...5 бүсийн хүн амын тооноос хамааруулж мандатын тоог тогтооно. ...Энэ 13-тын тогтолцоогоор зохион байгуулагдана. ...Улсын дээд хуралдай нь 3 жил тутамд хуралдана. ...Ээлжит бус дээд хуралдайг хуралдуулж болно. ...Монгол улс нь хууль тогтоох байгууллагатай байна. Түүнийг улсын доод хурал буюу хууль тогтоох байгууллага гэж нэрлэнэ. ...Түүний суудлын тоо 99 байна. Хууль тогтоох байгууллагын төлөөлөгч нарыг 6 жилийн хугацаагаар сонгоно. Хууль тогтоох байгууллагын төлөөлөгчдийг дээд хуралдайгаас сонгоно. Гурван жил тутамд нийт гишүүдийн 1/3-д нөхөн сонгууль явуулна. ...Монгол улсын газар, газрын хэвлийн баялаг Монгол улсын иргэн, ирээдүйн иргэний өмч мөн. ...Монгол улсын төрийн хамгаалалтанд байна. Монгол улсын Ерөнхийлөгч нь Засгийн газрыг тэргүүлнэ. Ерөнхийлөгч нь дээд хуралдайгаас сонгогдоно. Яамдыг сайд нар Хууль тогтоох байгуулагад давхар алба хашихгүй. Монгол улсын засаг захиргааны хуулийг өөрчилж 5 бүсийн зохион байгуулалтанд оруулна.

2.2. УЛСЫН ИХ ХУРЛЫГ ЗАСАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

1. Хууль тогтоох эрхийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй эрхийг хязгаарлан, эргүүлэн татдаг болно. 2024-2028 онуудыг алдагдалгүй төсөвтэй байхаар хуульчилна. Засаг захиргааны бүтцийн өөрчлөлт хийнэ. Улс төрийн намуудыг гишүүнчлэлгүй, бодлогын нам болгож хуульчилна. УИХ-ын болон Засгийн газрын гишүүнээр давхар ажиллахгүй байхыг хуульчилна. Хувь тэнцүүлсэн тогтолцоонд шилжүүлэхийг хуульчилна. 100% давхар тооллого хийхийг хуульчилна. Орон нутгийн сонгуульд иргэдээс нэр дэвшдэг болгож хуульчилна. Цахим эрх чөлөөг дэмжиж хуульчилна. Хүний эрхийн тухай хуулиудын заалтын хэрэгжилтийг мөрдүүлнэ.

2. Сонгох томилох эрхийн хүрээнд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн томилгоо хийнэ. Улсын Их Хурлын дэргэд Ахмадын дэд зөвлөл, Залуучуудын дэд зөвлөл, Эмэгтэйчүүдийн дэд зөвлөл, Хүүхдийн дэд зөвлөл байгуулна.

3. Хяналт тавих бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын тогтоолын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих байнгын хороо байгуулна. Иргэдийн хяналтын хараат бус, бие даасан Үндэсний хороо улс даяар байгуулна. Үндэсний хяналт, шалгалтын тухай хууль батлуулна.

2.3. ЗАСГИЙН ГАЗРЫГ ЗАСАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Засаглалын шинэчлэл хийнэ. Засгийн газрын бүтэц зохион байгуулалтыг үндэсээр нь шинэчилнэ. Монгол улсын засгийн газар 4 яам 12 дэд яам 5 сайдтай ажиллахаар зохион байгуулна.

Цахимжсан, язгуурын төрийн Засгийн газар байгуулна. Монголын төр цомхон, хүчтэй байхаар зохион байгуулна. Хиймэл оюун ухаанд суурилсан цахим шилжилт хийнэ.

Хүчтэй, давхар албагүй, хараат бус гүйцэтгэх засаглал байгуулна. Нийтээр хүлээн зөвшөөрсөн, мэргэжлийн Засгийн газар байгуулна. Засгийн газрын хэрэг эрхлэх газрыг шинэ ажил үүрэгт шилжүүлнэ.

12 яам бүрд 12 хүний бүрэлдэхүүнтэй салбарын эрдэмтдийн зөвлөлийн баг ажиллуулна.

Дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарыг ажил амьдралын туршлагатай мэргэшсэн 44+ настай хүнийг ажиллуулах бодлого барина.

Монголын шилдэг хүмүүсээ нам харгалзахгүй Монголын төрд зүтгэх шинэ тогтолцоонд шилжүүлнэ. Тиймээс мэдлэгтэй, мэргэшсэн, шударга, ёс суртахуунтай Монгол хүн бүр төрийн төлөө зүтгэхэд өөрийг бэлтгэж байх хэрэгтэй.

Гурван зарчмыг засаглалд хэлбэршүүлнэ. 1. Эрх мэдэл төвлөрүүлж, олон жилийн дураараа авирлах төөрөгдлийг арилгана. Нэгдмэл удирдлагад шилжүүлнэ. 2. Иргэний эрх хуулийн хүрээнд хүчтэй байх боломжийг нээнэ. 3. Хуулиар нийгмийн дүрмийг хасах хэв маягийг тогтоон барих бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

Ёс суртахуун суурьт хуулийн өмнө нийгмийн эмх журам төвшитгөдөг тогтолцоог бий болгоно. Эрх мэдэлтнүүд болон албан тушаалтнууд хариуцлагаа хүлээдэг хуулийн, иргэдийн хяналтын тогтолцоог бий болгоно.

Үрэлгэн, авлигажсан Засгийн газрыг засна. Яамдын тоог цөөрүүлнэ. Сайдын тоог цөөлнө. Төрийн албаны тухай хуулийн шаардлагад нийцүүлэн төрийн албан хаагчийн тоог бууруулж мэдлэг, ур чадвар, мерит зарчмаар шинэ зохион байгуулалтанд шилжүүлнэ.

Яамдын чиг үүргийг шинээр тодорхойлж, цомхон, мэргэжлийн, мэргэшсэн засгийн газрын сайд, дэд сайд, төрийн нарын бичгийн дарга нарыг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр иргэд, олон нийтэд танилцуулна.

Монгол улсын засгийн газрыг Ерөнхийлөгч удирддаг байхаар Үндсэн хуулинд өөрчлөлт оруулна.

2.4. САЛБАР ХУУЛИУДЫГ ЗАСАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Хуулийн шинэчлэл хийнэ. Ёс суртахуунд суурилсан хуулиуд шинээр баталж, өөрчлөлтүүд хийнэ.

Шүүхийн шинэчлэл хийнэ. Шүүхийн хараат бус байдлыг бодитоор бий болгоно. Төрийн төлөөлөл болсон шүүгч нь ард түмний төлөөлөлтэй хамтран Монгол улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргадаг байх зарчмыг сэргээн хэрэгжүүлнэ. Хүн өөрийгөө болон бусдыг өмгөөлөх эрхийг чөлөөтэй болгож хуульчилна.

Хууль сурталчлах ажиллагааг цахим хэлбэрт оруулж бодлогын шинэчлэлт хийнэ.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийг эцэс болгох тогтолцооны бодлого хэрэгжүүлж, хуулчилна.

Шинээр боловсруулж, батлуулах хуулиуд

Удмын тухай хууль

Хувийн мөрдлөгийн тухай

Улс төрийн намуудын тухай

Хандив тусламжийн тухай

Гаалийн татварын хөнгөлөлтийн тухай

Импортын татварын тухай

Татвар өгсөн иргэдийн хөнгөлөлтийн тухай

Үр хөндөлтийг зохицуулах тухай

Хар тамхины тухай

Хүүхдийн хүчирхийллийн тухай

Хүний эрхийн баталгаагтай хангуулах тухай

Авлига, төрийн өндөр албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх тухай

Үндэсний үнэт зүйлийн тухай

Үндэсний мэдээлэл хамгаалалтын тухай

Мөнгө хүүлэлтийн эсрэг хууль

Иргэний хяналтын тогтолцооны тухай

Тангарагтны тухай

Заргын тухай

Дижитал хамгаалалтын тухай

Хувь хүний нууцын тухай

Худалдаа, худалдаачдын тухай

Бусад хуулиуд



Нэмэлт өөрчлөлт оруулах хуулиуд

Татварын багц хууль

Боловсролын багц хууль

Эрүүл мэндийн багц хууль

Эрүүгийн багц хууль

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай

Зөрчлийн тухай

Төрийн бус байгууллагын тухай

Хэвлэл мэдээллий эрх чөлөөний тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хууль

Өргөн нэвтрүүлэгийн тухай

Эрүүгийн тухай

Иргэний бүртгэлийн тухай

Хуулийн этгээдийн эрхийн Улсын бүртгэлийн тухай

Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлийн тухай

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай

Зөрчил шалган шийдвэрлэх тухай

Прокурорын тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

Ахмад настны тухай

Авлигын эсрэг хууль

Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай

Ашигт малтмалын тухай

Бусад бодит байдалд нийцээгүй хуулиудад өөрчлөлт оруулна.

1.5. ТӨРИЙН “ХАР” ХҮНИЙГ БЭЛТГЭХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Төрийн үйлчилгээ, төрийн албаны шинэчлэл хийнэ. Хиймэл оюун ухаанд суурилсан төрийн үйлчилгээнд шилжүүлнэ. Ур чадварын өсөлт, ёс суртахуунтай, мэргэшсэн төрийн албан хаагчтай болно. Улс төрөөс ангид төрийн албыг бий болгоно.

Монгол залуусыг Монголыг дахин хүчирхэгжүүлэхэд зүтгэх хүч хэмээн хүндэтгэж, тэднийг гадаадын нэр хүнд бүхий 100 их сургуулиуд, нарийн мэргэжлийн сургуулиудад төрийн 100 хувийн зардлаар тодорхой зорилго, тусгай гэрээний дагуу бэлтгэх, чадваржуулах, мэдлэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /Ерөнхийлөгчийн илгээлт 2100/


Монголын залуучуудад зориулсан үндэсний үзлийг тусгасан тусгай хөтөлбөр боловсруулан төрийн дээд хүн бэлтгэх “Төрийн дээд хүн-2028” үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулж вакумжуулсан сургалт хэлбэрээр зохион байгуулна.

“Төрийн дээд хүн-2028” үндэсний хэмжээний хөтөлбөрийн хүрээнд төрийн хүн бэлтгэх төв их сургуулийг байгуулах, төрийн хөх хайрцагны бодлого боловсруулагч үндэсний нууц бодлогын хүрээлэн байгуулах, эх оронч үзлийг алхам тутамд шингээсэн институтчилсан сүлжээг бий болгоно.

Монгол улсын их сургуулийг төрийн хүн бэлтгэдэг тусгай хөтөлбөртэй болгож өөрчлөлт хийнэ. Улсын хэмжээнд сахилга хариуцлагын тогтолцоог сайжруулна. Мэргэжил, ур чадварын тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. Улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Төрийн албан хаагчдын амьдралыг баталгаажуулж, чин шударга төрийн албан хаагчдыг төр хамгаалдаг эрх зүйн орчиныг бий болгоно.

Иргэний хяналтын тогтолцооны хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх хуульчилж хасах, шүүхийн тогтолцооны хуулиудийн өөрчлөлтүүдийг хийж, төрийн албан хаагчидын үйлчилгээний соёл, сахилга бат сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.



1.6. ЁС СУРТАХУУНТ ИРГЭНИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Ёс суртахуунт иргэнийг төлөвшүүлэх ажлыг сургуулийн өмнөх боловсролоор дамжуулан багаас бэлтгэх бодлого барина.

Иргэний эрхийг үүргийн хамт, чөлөөт байдлыг сахилга батын хамт, эрх чөлөөг ёс суртахууны хамт төлөвшүүлэх бодлого барина.

Удмын хэлхээт хариуцлагын тогтолцоог сэргээж удмаар дамжин төрт ёсыг эмхэлдэг ёс суртахуунт иргэнийг төлөвшүүлнэ.

“Саруул Монгол” төрийн дээд хүн бэлтгэх бодлого хэрэгжүүлнэ. Дэлхийг харж, сэтгэдэг хүмүүсийг тусгай сургалтаар дамжуулан бэлтгэнэ.

Монголын ирээдүйн залуусыг дэлхийн хэмжээний бодлого боловсруулах чадвартай шинэ үеийн ёс суртахуунтай боловсон хүчинг бэлтгэнэ.

Өөрийгөө нээн олж, удам өвгөдөөсөө тусгай үйл хэрэг тээж төрсөн хүмүүсийг сэргэж өндийж, ёс суртахуунлаг иргэн бий болоход дэмжинэ.

3. “САН ХӨМРӨГТЭЙ МОНГОЛ” ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫГ ХУВЬСГАЛ

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

I үе шат (2021-2030): Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлэх, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх үе. 1.Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна. 2.Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна. 3.Гадаад валютын албан нөөц эрсдэл даахуйц хэмжээнд хүрч өссөн байна. 4.Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлт тасралтгүй нэмэгдсэн байна. 5.Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадвар дээшилсэн байна. 6.Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна.

Алсын хараа-2050 хөтөлбөрт нийцүүлэн боловсруулав.

Эдийн засгийн шинэчлэл хийнэ. Эдийн засгийн шинэчлэлийн гол зорилго нь ард түмэндээ ашиг хүртээх холч бодлого явуулна. Улсын эдийн засгийн бодлогыг чөлөөт зах зээлийн эдийн засгаас хамтын зах зээлийн эдийн засагт шилжүүлнэ.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлснээр Монгол Улс 2028 онд:

- ✦ Нэг хүнд ногдох Үндэсний нийт орлого 5 сая хүрч, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ.
- ✦ Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2024-2028 онд 6-9 хувиас доошгүй байна.
- ✦ Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 35 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.
- ✦ Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100 хувьд хүргэж, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлнэ.
- ✦ Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 70-д хүргэнэ.
- ✦ Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 50 орны нэг болно. Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 20 орны нэг болно. Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 60, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 50 орны нэг болно.
- ✦ Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна.

Макро эдийн засгийг засч, залруулах бодлого хэрэгжүүлнэ.

- ✦ 2024-2028 оны эдийн засгийн дундаж өсөлтийг 5.5 хувиас доошгүй байлгана.
- ✦ 2024-2028 оны нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах, төсвийн тэнцлийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ 10 хувь хүртэл бууруулна.
- ✦ 2024-2028 оны төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлах, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн нийт зарлага 2028 онд 32 хувь хүртэл бууруулна.
- ✦ 2024-2028 онд өрийн дээд хязгаарыг чанд сахин мөрдөж, өрийн зохистой түвшинг хангах, гадаад зах зээл дэх Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтмол дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ. В зэрэглэлээс ВВВ болгоно.

- ✦ 2024-2028 онд гадаад зах зээлийн болон түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзлээс сэргийлэх бодлогыг баримталж, хуримтлалын санг бий болгон арвижуулна.
- ✦ 2024-2028 онд гадаад валютын нөөцийн зохистой хэмжээг байнга бүрдүүлнэ.
- ✦ 2024-2028 онд төлбөрийн тэнцлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийг тогтвортой, нам түвшинд барина.
- ✦ 2024-2028 онд банк, санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, эрсдэлгүй, найдвартай байдлыг чанд хангаж, хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.
- ✦ 2024-2028 онд олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн шинжтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ.
- ✦ 2024-2028 онд хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллана.

3.1. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Аж үйлдвэрийн бодлогын шинэчлэл хийнэ. Хууль ёсны нэмүү өртөг шингээсэн 12 үйлдвэр байгуулна. Байгалийн нөхөн сэргээлтийн сан байгуулахыг хуульчилж, 21 аймагт нөхөн сэргээлт хийнэ.

Эдийн засгийн бодит салбаруудыг санхүүгийн бодлогоор дэмжих замаар түргэн хурдацтай хөгжүүлнэ. Өндөр технологид тулгуурлан стратегийн орд газруудыг ашиглаж, эдийн засгийн бодит салбаруудыг хөгжүүлэх санхүүгийн хуримтлалыг бүрдүүлнэ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт өндөр технологийг нэвтрүүлж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжинэ.


Өндөр технологийг тууштай нэвтрүүлж, экспортын баримжаатай, оюуны багтаамжтай, өрсөлдөх чадвартай, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжинэ.

Хувийн бол олон нийтийн өмчит улс дамжсан үйлдвэрүүд байгуулахыг төрөөс дэмжинэ.

10.000 ажилчинтай 12 үйлдвэрүүдийг байгуулахад бодлогоо чигүүлнэ. Иргэд хувьцааг нь эзэмшиж ашиг хүртэхээр хамтын зохион байгуулалтын хэлбэрт шилжүүлэхийг хуулчилна. Иргэдэд үйлдвэрүүдийг 22 хувийг эзэмшихээр зохицуулна.

Үүнд: Эдийн засгийн хөдөлгүүр хүч болсон 12 үйлдвэрийг байгуулна.

1. Газрын ховор элементийн боловсруулах үйлдвэр
2. Гангийн боловсруулах үйлдвэр
3. Нүүрс хийжүүлэх үйлдвэр
4. Занар боловсруулах үйлдвэр
5. Зэс хайлуулах үйлдвэр
6. Алт цэвэршүүлэх үйлдвэр
7. Газрын тос боловсруулах үйлдвэр
8. Байгалийн хий боловсруулах
9. Занар боловсруулах үйлдвэр



10. Нүүрс боловсруулах үйлдвэр
11. Чулуу боловсруулах үйлдвэр
12. Нүүрс коксжуулах үйлдвэр

Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээний 70 хүртэл хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангадаг болно.

Хөдөө аж ахуйн шинэчлэл, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, малын цогц эрүүлжүүлэлтийг хийнэ. Усалгаатай газар тариалан, эко бүтээгдэхүүнийг дэмжинэ.

Олон улсын стандарт, олон улсын зах зээлд өрсөлдөх тогтолцоог хэрэгжүүлнэ. Малын чанар, үржлийн ажлыг сайжруулж эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэхэд чиглэсэн бодлого явуулна.

Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, газарын бодлого тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжинэ.

Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг болон импортыг орлох хүнсний зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжих;


Бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлж тариалантай хослуулах.

Дэлхийн стандартад нийцсэн экспортын зорилтот 10 үйлдвэр байгуулна. Нийтийн, төрийн өмчит 21 дотоодын үйлдвэр байгуулна. Хүнсний хэрэглээний 78 хувийг дотооддоо хангана. Үндэсний брэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хоршиж ажиллах (кластер) тогтолцоог бий болгоно.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих санхүүгийн эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ. Экспортын баримжаатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн татварын бодлогоор дэмжих хуулийг анхлан санаачилаж УИХ-д өргөн барина.

Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлнэ.

1. Махны үйлдвэр
2. Сүүний үйлдвэр
3. Үндэсний уламжлалт үйлдвэрүүд
4. Био технологийн үйлдвэрүүд
5. Арьс ширний үйлдвэрүүд
6. Ноос, ноолуурын үйлдвэр
7. Уламжлалт үйлдвэрүүд
8. Вакцины үйлдвэрүүд
9. Тэжээлийн үйлдвэрүүд газар тариалан
10. Бордооны үйлдвэр
11. Эмийн үйлдвэр
12. Хүнсний үйлдвэр



3.2. АЛДАЛГҮЙ ХЯНАЛТТАЙ ТӨСӨВ, МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Төсвийн шинэчлэл хийнэ. 2025 он гэхэд алдагдалгүй төсөвтэй болно. Төсвийн зарцуулалтыг нийтийн хяналтанд шилжүүлнэ.

Валютын нөөцийг алтаар баталгаажуулах бодлого барина. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2024-2028 онд 8 хувь, Улсын төсвийг 2025 онд 27.757 их наяд, 2026 онд 29.155 их наяд, 2027 онд 30.555 их наяд, 2028 онд 32.358 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн.

Зарлагыг 2025 онд 28.624 их наяд, 2026 онд 29.266 их наяд, 2027 онд 29.234 их наяд, 2028 онд 31.358 их наяд байхаар тооцсон. 2025, 2026, 2027, 2028 онд улсын төсвийн орлогоос бондуудыг төлж барагдуулна. Төсвийн бодлого нь Улсын төсөв бүрдүүлэхийн зэрэгцээ дотоодын зах зээл, хүнсний аюулгүй байдлыг давхар

Энэхүү баримт бичгийг ашиг олох зорилгогүйгээр эх сурвалжийг заан бүтнээр болон хэсэгчлэн хувиар, нийлэх, цахим хэлбэрт оруулах бусад ямар нэг хэлбэрээр ашиглах нь нээлттэй. Оюуны өмчид бүртгэлтэй болно. Ух - Хуульчийн Монгол Консерватив нам гэж дурдаж ашиглана.

18

00000018

хамгаалж байх бодлогыг баримтална. /Монгол улсын 2022 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, Монгол банкны мэдээлэл/

Төсвийн зөв зарцуулалт, хуваарилалтыг иргэдийн хяналттай болгоно. Засгийн газар, Төв банк, төрийн өмчит арилжааны банкуудын гадаад өрийн менежментийг сайжруулна. Өр барагдуулах тусгай агентлаг байгуулах хууль эрх зүйн орчныг боловсруулж хийнэ.

Иргэдийн сайн дурын хуримтлалд тулгуурлан орон сууцны зээлийн хүүг бууруулна.

Арилжааны банкны стресс үнэлгээний үзүүлэлтийг тогтоож сар, улирал бүр иргэд, аж ахуйн нэгжүүдэд улирал бүр зарлаж байна. Иргэд, аж ахуйн нэгжийг "Зээлжих чадварын үнэлгээ"-ний цахим карттай болгох бодлого боловсруулна.

Улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангаж, орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

Төсвийн хөрөнгө оруулалтыг судалгаанд суурилсан хөгжлийн стратеги бодлоготой уялдуулан төсөл, хөтөлбөрийг хэрэгцээ шаардлагын эрэмбийн судалгаанд тулгуурлан Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлнэ.

Бүсүүдийн хөгжлийг хурдасгах төслүүдийг орон нутгийн засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэх бодлого барина. Эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн паркууд барих, шаардлагатай дэд бүтцийг шийдвэрлэнэ.

Хүний хөгжлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. Тэтгэвэр, тэтгэмжийг үндэсний орлогын өсөлттэй оновчтой уялдуулан нэмэгдүүлнэ.

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийг тогтвортой нам түвшинд барьж, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангана. Эрэлтийн болон нийлүүлэлтийг инфляциас хамгаалах оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ. Гадаад валютын цэвэр албан нөөцийг эдийн засгийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.

Хөрөнгийн зах зээлийг сонгомол утгаар нь хөгжүүлнэ. Өрсөлдөх чадвар бүхий үнэт цаасыг гадаад зах зээлд гаргаж, хөрөнгийн гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

Гадаад зээлийн хэмжээг зохистой түвшинд байлгаж, өрийн эрсдэлийг бууруулна. Тухайн жилд авч болох зээлийн дээд хязгаарыг Засгийн газар тооцож, УИХ баталдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. ДНБ-д эзлэх гадаад зээлийн хэмжээг зохистой түвшинд барина. Олон улсын санхүүгийн байгууллагууд, донор орнуудаас эдийн засаг, санхүүгийн хувьд өндөр үр ашигтай зээл авах чиглэлийг баримтлана. Гадаад зээлийн үр дүн, өгөөжийг нь тооцдог бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгоно. Дотоодын санхүүгийн зах зээлийг хөгжүүлж, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх замаар гадаадын зээл, тусламжаас хамаарах хамаарлыг багасгана.

Хүнээ хөгжүүлж, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн хөрөнгө оруулалтын бодлого явуулна. Гадаадын мэдлэгжсэн өндөр технологид нэвтрэх боломжийг санхүүгийн бодлогоор дэмжинэ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, өндөр технологи нутагшуулахад хууль, эрх зүйг хуульчилна.

3.3. БАГА ТАТВАРЫН ТОГТОЛЦОО БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Татварын шинэчлэл хийнэ. Ялгаатай, дарамтгүй татвар төлдөг тогтолцоонд шилжүүлнэ. Татварын шинэчлэл хийнэ. Ялгаатай, дарамтгүй татвар төлдөг тогтолцоонд шилжүүлнэ. НӨАТ-ын бодлогод өөрчлөлт оруулан хуульчилна.

Татварын суурийг өөрчилж бага хувьтай, ялгаатай татварын тогтолцоог хэрэгжүүлнэ. Нийгмийн даатгалыг шимтгэлийн хувь хэмжээг бууруулах бодлого барина.

Экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээ, импортыг өрлөх үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжинэ.

Эрдэс түүхий эд, ноос, ноолуур, мах, сүү, арьс шир боловсруулах салбарын үйлдвэрлэлд өндөр технологи нэвтрүүлэхийг татварын бодлогоор дэмжихийг хуульчилж мөрдүүлнэ. Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих бодлого боловсруулж, хуулийн төслийг бэлтгэнэ.

Экспортын баримжаатай "Бренд" бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжихэд онцгойлон анхаарч ажиллана.

Татварын бааз суурийг өргөтгөж, бага татвар авах бодлогыг хэрэгжүүлнэ. Татварын ачааллыг зохистой нам түвшинд барина. Татварын бааз суурийг жил бүрийн инфляцтай уялдуулан шинэчилнэ. Цахим татварын системийг үргэлжүүлэн хөгжүүлнэ.

Бүс нутгийн хөгжлийг татварын бодлогоор дэмжинэ. Бүс нутгуудын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг татварын бодлогоор дэмжих; Бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийг татварын бодлогоор дэмжинэ. Улсын хил орчмын бүс нутгийн хөгжлийг татварын бодлогоор дэмжинэ.

Эдийн засаг, үйлдвэрлэлийг дэмжих гаалийн, онцгой, ашгийн татварын зохистой бодлого явуулна.

3.4. БАЯЛАГЫГ УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛ

Эрдэс баялагын хуваарилалтын шинэчлэл хийнэ. Монгол улсын үндсэн хуулийн 6.2 заалтыг "Монгол улсын газар, түүний хэвлийн баялаг нь ард түмний, ирээдүйн иргэний өмч мөн." гэж өөрчилнэ.

Стратегийн ордуудад тулгуурлан олон улсын хөрөнгийн бирж дээр санхүүжилт /IPO/ босгоно.

Шинээр мэндэлсэн иргэн бүрт 22 000 000 төгрөгтэй тэнцэх хэмжээний өсөн нэмэгдэх хувьцаа эзэмшиж болох талаар судалгааг хийнэ.

Хууль бус лицензийг цуцлаж, хайгуулын болон ашиглалтын лицензийн эрхүүдийг цэгцлэнэ. Байгалийн баялаг ашиглагч гадаад дотоодын аж ахуйн нэгж байгууллага нь олон нийтэл нээлттэй хувьцаат хэлбэрээр ажиллахыг хуульчилна.

Байгалийн баялагаас олох бүх орлогыг Үндэсний нэгдсэн хөрөнгө оруулалтын санд төвлөрүүлнэ.

Нөхөн сэргээлт хийгээгүй, голын голидрол, байгалийн зүй тогтолын эвдсэн бүх уул уурхай лицензүүдийг хүчингүй болгоно.

3.5. САНГУУДЫН УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛ

Үндэстний Нэгдсэн Хөрөнгө Оруулалтын Санг байгуулна. Бүх сангуудийг нэг удирдлагатай болгож хуульчилна. Улс төрчдөөс хараат бус байхаар хуульчилна.

Үндэсний хөрөнгө оруулалтын санг улс дамнасан үйлдвэрүүд бий болгох, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, макро эдийн засгийн тогтворжилтыг хангахад ашиглана.

Үндэсний нэгдсэн хөрөнгө оруулалтын сангийн эх үүсвэрийг Монгол улсын ашигт малтмал, байгалын баялагийн нөөц, гадаад валютын нөөц, тэтгэврийн сан, даатгалын сан, үндэстний төрийн өмчит корпорациудын орлогын эх үүсвэр, яамуудад буй бүх сангуудыг нэгтгэж шийднэ.

Үндэстний Нэгдсэн Хөрөнгө Оруулалтын сан үндсэн дөрвөн зорилготойгоор үйл ажиллагаа явуулна.

Нэгд нь хувийн, олон нийтийн өмчит дотоодын үйлдвэр, компаниудаа дэмжиж дэлхийн гаргах зорилготой. Үйлдвэр компаниудын хувьцааг ард түмэнд эзэмшүүлэхээр хуульчлана.

Хоёрт дэлхийн гарсан байгууллагуудаа байнгийн дэмжлэг үзүүлж дэмжих зорилготой.

Гурав дахь нь дэлхийн санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх зорилготой. Зах зээлд амжилттай яваа гадаадын корпорациудад хөрөнгө оруулалт хийх зорилготой.

Дөрөв дахь нь дотоодын үнийн өсөлт, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилготой.

Сэргэн мандалтын тусгай данс нээнэ. Сэргэн мандалтын тусгай данс нь Үндэсний Нэгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэг эх үүсвэр болно. Мэргэн мандалтын тусгай дансны эх үүсвэр нь дараах байдлаар бүрдэнэ.

Гадаад дахь хууль бус үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг хуулийн хүрээнд хайр найргүй хураана. Үндэслэлгүй хөрөнгөжсөн хүмүүсийн хөрөнгө, хууль бус хөрөнгө хураана. Авлиагчдыг мөрдөх, үйлдлийг таслан зогсоох, илчлэх үйл ажиллагаа эрчимжүүлнэ.

Алдсан ард түмний эд хөрөнгийг яаралтай олж авахын тулд орлогын эх үүсвэрээ шударга хөдөлмөрөөр олж авч чадаагүй хүмүүсийн эд хөрөнгийг Монгол улсын сэргэн мандалтын тусгай данс нээж яаралтай төвлөрүүлэх хуулиудыг батлуулж хэрэгжүүлнэ. Ард түмний өмч, бүтээн байгуулалтыг өмч хувьчлал нэрээр хувьдаа завшсан нөхдийн үйлдлийг илрүүлж тэдний ард түмнийг хохироосон хохирлыг тогтоож, сэргэн мандалтын тусгай дансанд татан төлөвлөрүүлнэ.

Газрын хэвлийн баялагийг хувийн эрх ашгийн зорилгоор ашиглан ард түмэнд өгөөжгүйгээр хувьдаа завшигч нарын жагсаалтыг гаргаж, нөхөн төлбөр хэлбэрээр төвлөрүүлж, сэргэн мандалтын тусгай дансанд байрлуулна.

Авилга авч баяжсан нөхдийг хуулийн хүрээнд илрүүлж, тэдний авилгаар авсан мөнгийг сэргэн мандалтын тусгай дансанд татан төвлөрүүлнэ. Татварын мөнгөөр тендер, худалдан авалт, шахаа хийх замаар шамшигдуулсан мөнгийг эргүүлэн татаж, сэргэн мандалтын тусгай дансанд төвлөрүүлнэ.

Офшорт хууль бус мөнгө байргуулсан этгээдийг Олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж хууль бус мөнгийг сэргэн мандалтын тусгай дансанд татан төвлөрүүлнэ. Улс дамнасан мөнгө угаасан гэмт хэргийн чанартай үйлдэл хийсэн нөхдийн мөнгийг илрүүлж, сэргэн мандалтын тусгай дансанд татан төвлөрүүлнэ.

3.6. ХУВИЙН ӨМЧИЙГ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Хувийн өмчийг хамгаалах тухай хуулийг Улсын Их хурлаар батлан мөрдүүлнэ.

Хувийн болон олон нитийн өмчит улс дамнасан үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтыг Үндэсний Нэгдсэн хөрөнгө оруулалтын сангаас санхүүжүүлнэ.

Монгол хүний мэдлэгт тулгуурлан Монгол хүнд эдийн засгийн өгөөж авчрах дотоодын болон үндэстэн дамнасан корпорациудыг байгуулан дэлхийн зах зээлд өрсөлдөх нөхцөлийг хангана.

Улс дамнасан үйл ажиллагаа явуулдаг судалгаа, үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээ бүхий Монгол үндэстний олон нийтийн өмчит үндэстний корпорациудыг байгуулна. "R and D" үндэстний корпорациудыг судалгаа хөгжлийн байгууллагууд, борлуулалт маркетингийн сүлжээ, мэдлэгт тулгуурласан үйлдвэрүүдээ байгуулах суурь судалгааг гаргаж, тусгайлсан үндэсний хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

4. “СЭТГЭЛТЭЙ МОНГОЛ” НИЙГМИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

4.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Ангаагаахын салбарыг урьдчилан сэргийлэх тогтолцоонд шилжүүлнэ.

Эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэлхийнэ.

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог төрийн ба хувийн даатгалын холсолсон тогтолцоонд шилжүүлэхийг хуульчилна.

Монгол хүн бүрд зорилото цогц эрүүл мэндийн шинжилгээг хийж, эрүүл мэндийн суурь судалгааг хийнэ.

Суурь судалгаанд үндэслэсэн зорилтот эмчилгээг орон даяар хэрэгжүүлнэ.

Улаанбаатарт Эх нялхас II төрөх эмнэлэг, бүсүүдэд эх нялхасын 5 эмнэлэг барина.

Улаанбаатарт нарийн мэргэжлийн 2, бүсүүдэд 5 нарийн мэргэжлийн эмнэлэг, эрүүл мэндийн судалгаа, хөгжил, шинжилгээний эмнэлэг барина.

Улс орон даяар эмч, эмнэлэгийн ажилтаны цалинг нэмэгдүүлнэ.

Олон нийтийн өмчит эм, эмнэлэгийг хэрэгсэлийн үйлдвэрийг байгуулна. Эмийн хангамжийг дотоод үйлдвэрлэх ажлыг эхлүүлнэ.

Хувийн өмчөөр байгуулсан эмийн үйлдвэрийг төрөөс бодлогоор дэмжихнэ.

Өвчин туссан хойно нь эмчлэх биш урьдчилан сэргийлж, хамгаалах бодлогыг чухалчилна. Нийтийн биеийн тамирыг дэмжиж, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх, хот суурин, хорооллын төлөвлөлтөнд цэцэрлэгт хүрээлэн, гүйлт, дугуйн зам, усан сан зэргийг заавал тусгах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

ЭМД-ын оновчтой, үр дүнтэй, энэрэнгүй хувилбарыг боловсруулж нэвтрүүлнэ. Хүн амын өсөлт нь улсын хөгжлийн чухал хэсэг бөгөөд эдийн засгийн эрчимтэй өсөлтийн гол үзүүлэлт гэж үзнэ. Улсын орны эдийн засгийн чадавхи сайжирч, иргэдийн ирээдүйдээ итгэх итгэл нэмэгдэх нь хүн амын өсөлтөнд сайнаар нөлөөлөх тул урамшууллын оновчтой бодлого нэвтрүүлнэ.

4.2. ХАЛАМЖИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Тэтгэврийн шинэчлэл хийнэ. Төрийн болон хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоонд шилжүүлэхийг хуульчилна. Тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх бодлого барина. Оюутан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамтын хариуцлага хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулна. Гадаадад байгаа иргэдээ Монголын төр нэг бүрчлэн хамгаална.

Монгол өндөр настныг төрийн хамгаалалтад авна. Тэтгэврийн ялгааг арилгаж, залгамж тэтгэвэрийн тогтолцоог хэрэгжүүлнэ.

Эм тариа, эмчилгээ гэх мэт эрүүл мэндийн бүх эмчилгээ үйлчилгээнд хүртээмжтэй хамрагдах орчиныг сайжруулсан, байгалийн үзэсгэлэнт газар, орчин үеийн технологиор тоноглогдсон бие чийрэгжүүлэлт, эрүүл мэндийн үйлчилгээ, асаргаа сувилгааны бүтэн цогц үйлчилгээтэй газруудыг байгуулна.

Бие дааж амьдрах болон хөдөлмөрлөх чадвар нь хязгаарлагдмал иргэдийг төр хамгаална. Бие дааж амьдрах болон хөдөлмөрлөх чадвар нь хязгаарлагдмал иргэдийг онцгой анхаарч, тэднийг энгийн хүн шиг амьдрах баталгаа бий болгоно.

Гудамж талбай, байшин барилга, орц, зам зэрэгт тэдэнд зориулсан гарц замуудыг стандартчлан тогтоож мөрдүүлнэ. Оюутан суралцагч нартай харилцан гэрээ байгуулж бие дааж амьдрах болон хөдөлмөрлөх чадвар нь хязгаарлагдмал иргэдтэй харилцан туслалцах байдлаар аж төрөх боломжийг бүрдүүлнэ.

Гадаадад амьдарч буй 300 000 гаруй иргэдээ төр хамгаална. Монголоос бусад улсад аль ч хэлбэрээр ажиллаж, амьдарч, аялж яваа Монгол улсын иргэдэд зориулсан нийгмийн бодлогыг бас орхигдуулахгүй.

Монгол хүн гадны аль нэгэн улсад явж байгаад ямар нэгэн асуудалд орсон тохиолдолд Монголын төр иргэнийхээ төлөө ажиллах болно. Аль ч оронд байгаагаас үл хамааран Монголын төр иргэн дээрээ очиж үйлчилдэг болгоно.

4.3. ӨВ, СОЁЛ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Үндэсний өв, соёл нь монгол үндэстний оршин тогтнох, уламжлалт онцлогоо хадгалах нандин дархлаа бөгөөд дэлхий дахинд биднийг таниулах хүчирхэг хэрэгсэл хэмээн үзнэ.


Өв, соёлын бодлогын шинэчлэл хийнэ. Үндэсний язгуур урлагийг хөгжүүлэх шинэ бодлогод шилжүүлнэ.

Түүхэн явцад алдагдсан өв, соёлын зүйлсийг Монголд оронд авчирах ажиллагаа явуулна.

Түүхийн булш, бунхан, оргуулга, хяргасан үүрүүдийг төрийн тусгай хамгаалалтанд авна.

Түүх, археологийн салбарыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх бодлого баримтална. Археологийн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг дэмжиж, төрийн тусгай хамгаалалтанд авна. Орчин үеийн урлагийг чөлөөлт өрсөлдөөний бодлогоор дэмжинэ.

Сонгодог урлагийг төрөөс санхүүжүүлэх бодлого гаргана. Монголын урлагийн бүх салбарын хөгийг 432, 528 герц давтамжинд шилжүүлэхийг хуульчилна. Үндэсний урлаг соёл нь Монгол үндэстний оршин тогтнох, уламжлалт онцлогоо хадгалах нандин дархлаа бөгөөд дэлхий дахинд биднийг таниулах хүчирхэг хэрэгсэл хэмээн үзэж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.



4.4. ДЭД БҮТЦИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Газар, бүтээн байгуулалт, барилга, эрчим хүч, харилцаа холбоо, зам тээвэр, дэд бүтцийн бодлогод шинэчлэл хийнэ. Газрын тухай хуулийг эргэн харж өөрчлөлт оруулна.

Улаанбаатар хот Хархорин сумийн хурдны төмөр замаар холбож, баруун болон зүүн, хойд болон өмнөд бүсүүдийг Хархорин сумтай төмөр замаар холбож, ачаа тээврийн коридоруудыг үүсгэнэ.

Олон улсын төмөр замын тээврийн тээвэр ложистикийн төвийг байгуулж, транзит тээврийг хөгжүүлж, дэлхийн зах зээлтэй холбоно.

Баруун болон зүүн, хойд болон өмнөд бүсүүдийг Хархорин сумтай 4 эгнээ, Улаанбаатар Хархорин сумыг 8 эгнээ авто замаар холбоно.

Орхоны хөндий Хархорин орчимд олон улсын зэрэглэл бүхий шинэ нисэх онгоцны буудал байгуулна.

Агаарын тээврийн ложистикийн олон улсын төв байгуулж, ачаа тээвэр болон хүн тээврийн дамжин өнгөрөх гүүр болно.

Шинэ нийслэл, бүсийн хөгжлийн хотуудад инженерийн шугам сүлжээг шинээр төлөвлөн зохион байгуулж, инженерийн шугам сүлжээний дэд бүтцийг эхэлж байгуулна.

Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээг дахин төлөвлөлт хийж, иргэний хувийн өмчийг хамгаалсан байдлаар зохион байгуулна.

Бүх бүтээн байгуулалтыг харьяалах нэг яаманд шилжүүлж нэгдсэн бодлогоор барина. 0,7 га газартаа хувийн сууц барих 3 хувийн хүүтэй иргэдийн сайн дурын нийтийн хуримтлалын сан байгуулах эрх зүйн орчныг бий болгоно. Худалдан авах чадварт тохирсон орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хот байгуулалтын бодлогоор дэмжиж, Монгол улсын бүс нутгуудын түвшинд хот суурин газруудын ангилал зэрэглэлийг тогтоож хот, тосгоны төлөвлөлтийг боловсронгуй болгоход чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Энэхүү баримт бичгийг ашиг олох зорилгогүйгээр эх сурвалжийг заан бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, цахим хэлбэрт оруулах бусад ямар нэг хэлбэрээр ашиглах нь нээлттэй. Оюуны өмчид бүртгэлтэй болно. Эх сурвалжийг Монгол Консерватив нам гэж дурдаж ашиглана.

Орчин үеийн чанарын шаардлагыг хангасан барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Орон нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжинэ.

V цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчний дэд станцууд байгуулахыг бодлогоор дэмжинэ. Төмөр зам, авто зам, тээвэр ложистикын нэгдсэн сүлжээг байгуулахыг бодлогоор дэмжинэ. Өндөр хурдны интернетийн сүлжээ, өргөн зурвасын интернетийн үйлчилгээнд шижлүүлнэ.

Эрчим хүч гаргах боломжит эх үүсвэрүүдийг дэвшилтэт технологид тулгуурлан эрчим хүч экспорлогч орон болох холч бодлого хэрэгжүүлнэ. Эрчим хүчийг бие даан үйлдвэрлэхэд бодлогоо чиглүүлнэ.

Нүүрсний ордуудад тулгуурлан өмнөд хил дагуу дулааны цахилгаан станцуудыг байгуулах суурь судалгааг гаргана. Говийн бүсийн хотыг хангаж, урд хөрш рүү экспортлох бодлоготойгоор суурь судалгаа хийнэ.

Нар, салхи, газ сэргээгдэх эрчим хүчний үүсвэрийг дэмжиж, иргэнээсээ илүүдэл эрчим хүчийг төр худалдан авдаг тогтолцоог бий болгохыг зорино.

Улаанбаатар хотын эрчим хүчний хангамжийг сайжруулах асуудлыг дэмжиж бага оворын 3-50 мегабатт-ын цахилгаан станцуудыг дүүрэг бүрт байгуулах ажлыг судална.

4.5. БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Ясли, СӨБ, ЕБС хамрагдалтыг 100%-ийг хамруулах нөхцөл бүрдүүлнэ. Болосвролын шинэчлэл хийнэ. Ясли, СӨБ, ЕБС-ыг орон даяар нэг хөтөлбөрт шилжүүлнэ. Хүүхэд бүрийг цахим сурах бичигтэй болгохыг дэмжинэ

Шударга өрсөлдөөний шалгаруулалт, дижитал шалгаруулалтад шилжүүлнэ. Бодлогын сургууль, төлбөргүй сод оюутан тэтгэлэгт оюутан хөтөлбөр хэрэгжүүлнэ. Сургууль бүрийн дэргэд судалгаа, эрдэм шинжилгээ, технологийн иж бүрэн лаборатори байгуулж стандарчлан мөрдүүлнэ.

Үндсэн хуулинд заасан хувь хүний үндсэн эрхүүдийг амьдралд баталгаажуулах бодлого явуулна. Монгол хүний амьдралын стандартыг тогтоож, Монгол хүн Монгол газар нутагт нэгдүгээрт байхыг баталгаажуулна. Нэг ч Монгол хүнийг төрийн хамгаалалтын гадна байлгахгүй байх бодлогыг хэрэгжүүлнэ.


Монгол хүүхдэд монгол хүн үзлийг багаас нь суулгана. Хүүхдийг 12 нас хүртэл нь Монгол хэл эзэмшүүлнэ. Монгол хэл нь Монгол сэтгэлгээний үндэс тул эх хэлээ хамгаалах, зөв дэлгэрүүлэх, хөгжүүлэх бодлого баримтална.

Монгол оюутныг шударга шалгуураар улсын сургуульд суралцах өрсөлдөөнийг бий болгоно. Их дээд сургуулиудыг нүүлгэнэ. Их дээд сургуулиудын багш оюутны амьдрах байртай сурах бүх бололцоог цогцоор нь шийдсэн хотхон шинээр байгуулахыг төсөвт суулгана.

Ахмадуудад зориулан үндэсний хэмжээний “Өвлөх эрдэм-78/22” хөтөлбөрийг боловсруулж ахмадын захиасыг хэрэгжүүлэх бодлогын төвийг байгуулж ажиллуулна. Улсын төсвөөр шийднэ.

Боловсролын салбар тэргүүлэх онцгой салбар, онцгой хандлага, бодлого шаардлагатай суурь салбар. Боловсролын салбарыг онцгойлон анхаарах бодлого хэрэгжүүлнэ.

Боловсролын хөтөлбөр тогтолцоог туршилтын талбар болгохыг нэн даруй зогсоож, үндэсний эрдэмтэн мэргэд, багш сурган хүмүүжүүлэгч нарын хүчээр үндэсний онцлогийг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулна. Боловсролын хөтөлбөр нь сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах сургуулийн боловсрол,



мэргэжлийн, тусгай, дээд боловсролын зэрэг бүх салбар шатлалыг хамарсан шинжлэх ухаанч, цогц бодлого байна.

Боловсролын салбарын хөгжлийн хөшүүрэг нь багш, сурган хүмүүжүүлэгчдийн цалин хөлс, хөдөлмөрийн үнэлгээ, нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл бөгөөд багш нарын нийгмийн баталгааг сайжруулна. Багш нарын цалинг нэмэгдүүлэхээр хуульчилна.

Шинжлэх ухаанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг ҮДНБ-ний 2.5 хувьд хүргэнэ.

Үндэстний стратегийн технологи, стратегийн инновацын нийт төсвийн хэмжээг ҮДНБ-ний 2 хувиас багагүй байлгана Үндэстний стратегийн технологи, стратегийн инновацын төв байгуулна. Шинэ нээлт, хөрөнгө оруулалт, шинэ бизнес шатлалд оруулна.

Монгол үндэстний шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд Үндэстний хөрөнгө оруулалтын сангаас шууд санхүүжүүлж, шинэ менежмент нэвтрүүлнэ.

4.6. АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Аялал жуулчлалын бодлогын шинэчлэл хийнэ. Монгол улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болгох зорилгын хүрээнд аялал жуулчлалын 4 цогцолбор төвийг бодлогоор байгуулах Алтан дөрвөлжин судалгаа хийнэ. Зүүн бүсийн хөгжлийн хотод орчимд (Хэнтий аймаг) Тэнгэрийн хаан (Heaven King) цогцолбор төсөл, Хангайн бүсийн хөгжлийн хот орчимд (Хөвсгөл) Дэлхийн бөө мөргөлийн төв (World Shamanism Center) цогцолбор төсөл, Баруун бүсийн хөгжлийн хот орчим (Говь-Алтай) Дэлхийн диваажингийн төв (World Shambala Center) төсөл, Говийн бүсийн хөгжлийн хот орчимд (Өмнөговь) Олон улсын сансарын судалгаа, хөгжлийн төв (International Space R and D) (V mars төслийг дэмжих). Эдгээр төслүүдийг стратегийн ач холбогдолтой хэмээн үзэж олон улсын хамтын ажиллагааны хөрөнгө оруулалт, Үндэстний нэгдсэн хөрөнгө оруулалтын сангаас санхүүжүүлнэ.

Орхоны хөндийд Дэлхийн төрт төсний түүхэн цогцолборуудыг сэргээн байгуулна. Орхоны хөндийд байрлах Их Монгол улсын нийслэл Хархорум хотын туурийг сэргээж төрийн хүндэтгэлийн цогцолбор болгоно. Хүннү гүрний Луут хотын туурийг сэргээж төрийн хүндэтгэлийн цогцолбор болгоно. Бусад Хөх Түрэг, Уйгар, Сянби, Зүүн гарын хаант улсын үеийн хотуудыг сэргээн байгуулах судалгааг хийнэ.

Жуулчин үндэстний нэгдмэл хөтөлбөр хэрэгжүүлнэ. Жуулчин тээвэрлэлтийн болон жуулчин хүлээн авах байрны хүчин чадлыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын гол бүс нутгийн зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

Дээд зэрэглэлийн зочид буудал байгуулах зэрэг аялал жуулчлалын салбарт оруулах хувийн хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжинэ.

5. “СҮЙХЭЭТЭЙ МОНГОЛ” ГАДААД БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ” гэж заасан.

5.1. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.

Үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсэг болох Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал, нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал, Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдал, экологийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал зэрэгт суурь судалгаа, шинжилгээ хийнэ.

Аюулгүй байдал хэвийн байгаа эсэхийг шалгаж үзнэ. Аюулгүй байдлын итгэлцүүрийг шинээр гаргаж байнгийн хяналтанд байлгана.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг эргэн харж бүрэлдэхүүнийг өргөтгөх талаар судалгаа хийнэ.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийг шинэчлэн найруулна.

5.2. ГАДААДЫН ЭЛЧИН, ТӨЛӨӨЛӨГЧИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Гадаад улсуудад суух бүрэн эрхтэй элчин, элчин, ерөнхий консул, консулуудын үйл ажиллагаанд шинэчлэлт хийнэ.

Элчингийн бодлогыг шинэчлэн хуульчилж, гадаад бодлогын шинэчлэлтэй уялдуулж өөрчлөлтүүд хийнэ.

Монгол үндэсний язгуур эрх ашгаар л гадаад бодлогын зорилтоо тодорхойлно. Монгол улсын язгуурын үнэт зүйлийг хамгаалсан бодлого хэрэгжүүлнэ.

Монгол улс тусгаар тогтносон, бие даасан энх тайванч дипломат бодлого эрс хэлбэрэлтгүй хэрэгжүүлнэ.

Ард түмний эсрэг гадны ил далд бодлогуудыг таслан зогсоож, гаднаас нөлөөлөх боломжийг хязгаарлах замаар Үндэстний бие даасан холч бодлого хэрэгжүүлнэ.

5.3. БАТЛАХ ХАМГААЛАХ, АЮУЛААС ХАМГААЛАХ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Батлан хамгаалах салбарыг цахимжуулна. Технологийн дэвшилийг нэвтрүүлнэ. Сүүлийн үеийн хиймэл оюун ухаан суурилсан ухаалаг тоног төхөөрөмжүүдийг нэвтрүүлнэ.

Үндэстний аюулгүй байдлыг дархлаажуулалтын хүн бүрт суулгах хөтөлбөрийг цэргийн анги, батлах хамгаалах хүчинд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Монгол хүнийг эрүүл мэнд, эх оронч, сахилга баттай, хүмүүжилтэй, эрэлхэг, баатарлаг, нийтэч, ахан дүүсэг, эв нэгдэлтэй, шударга, шулуун эрдэмтэй болгохын цалинтай цэргийн алба хаалгахыг хуульчилна.

Байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс үүсэх гамшигийн аюулаас хамгаалах тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.

Бүх нийтийн цэрэг хөтөлбөр, эмэгтэйчүүд сайн дураараа явдаг болно. Дэвшилтэт техник, технологийн хөрөнгө оруулалт хийж хилийн хамгаалалтыг өндөржүүлнэ.

Иргэн бүр эрх орноо хамгаалагч хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Хилийн бүсийн дагуу амьдарч буй малчин айл өрх, нутгийн иргэдийг тусгайлан бэлтгэж, хилийн хамгаалагчийн урамшууллыг олгохыг хуулчилна.

Бүх нийтийн эрүүл чийрэг байдлыг батлан хамгаалах салбарын бодлоготой уялдууна. Бүх нийтийн спортын үйл ажиллагааг төрөөс бодлогоор дэмжинэ. Мэргэжлийн спортоор өрсөлдөх залуучуудыг төрийн бодлогоор хөгжүүлнэ.

Хугацаат цэргийн алба нь батлан хамгаалахын үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ залуучуудыг эх оронч сэтгэлтэй, бие бялдар, хүмүүжлийн өв тэгш хөгжилтэй, хамтран ажиллах чадвартай, бүтээн байгуулах тэмүүлэлтэй болгох сургалт хүмүүжлийн оновчтой хөтөлбөр хэрэгжүүлнэ. Мэргэжлийн болон их спортыг дэмжих бодлого баримтална.

5.4. ХЯТАД УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

БНХАУ-тай холч хараатай стратегийн түншлэлийн харилцааг хадгалах бодлого, сайн хөршийн харилцан итгэлцлэлийн найрсаг харилцаагаа хадгалах бодлого явуулна.

2011 оноос Стратегийн түншлэлийн харилцаатай болоод байсан манай хоёр улс 2014 онд “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурснаар иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай болсон. Уг тунхаглалыг шинэчлэн шинэ түвшинд харилцааг зохицуулах санаачлага гарган ажиллана.

Эртний төрт ёсны түүхэн харилцааг судлах хамтарсан судалгааны баг гаргаж ажиллуулна.

Хархорин хамтын ажиллагааны байгууллагыг санаачилж түүхийн судалгааны ажлыг эрчимжүүлнэ.

Хятад улсад ажиллаж амьдарч буй Монголчуудын эрх ашгийг хамгаалах талаар санал солилцох, судалгааны ажил эхлүүлнэ.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад хандах хандлагаа өөрчлөх эрх ашгийн суурь судалгаа хийнэ.

5.5. ОРОС УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай Оросын холбооны улсын хувьд 2019 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын гэрээ”-г шинэчлэн шинэ түвшинд гаргах гэрээг санаалан хийнэ.

Эртний уламжлалт төр ёсны харилцааг судлах судалгааны хамтарсан баг гаргаж ажиллуулна.

Орос улсад амьдарч буй Монголчуудыг эрх ашгийг Олон улсын хуулийн хүрээнд хамгаалах талаархи талаар санал солилцоно.

БРИКС-ын талаар баримтлах байр суурь хандлагадаа судалгаа, дүгнэлт хийнэ.

5.6. БУСАД УЛСУУДЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Дэлхийн болон бүс нутгийн худалдааны интеграцид идэвхтэй оролцож, байр сууриа бэхжүүлэхэд чиглэсэн гадаад харилцааны бодлого явуулна.

Америкийн нэгдсэн улс, Япон улс, Ардчилсан Солонгос улс, Холбооны бүгд найрамдах Герман улс зэрэг гуравдагч хөршүүдтэй гурван тулгуурт стратегийн иж бүрэн түншлэлийг өргөжүүлж, үргэлжлүүлнэ.

Дипломат харилцаа тогтоосон бүх улсуудын гэрээ, тунхаг, хамтын ажиллагааны санамж бичгүүдийг эргэн харж улс хоорондын хамтын ажиллагааг шинэ түвшинд гүнгийрүүлэн хөгжүүлнэ.

Бүс нутгийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны байгууллагуудын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

6. “СҮЛДТЭЙ МОНГОЛ” БИЛИГ ЭРДМИЙН ХУВЬСГА

6.1. ТЭНГЭРИЙН ӨНГӨТ СҮЛДНИЙ ДУУЛАЛ

- Тэнгэрийн хаадын ивээлээр
- Тэгш дүүрэн сэнтийлсэн өнгөт сүлд
- Тив дэлхийг дамнан
- Түүчээлж сэнтийлсэн өнгөт сүлд
- Орчилын их эрчимийг
- Оршоож татсан өнгөт сүлд
- Гэрэлт галын хүчийг
- Гагнаж татсан өнгөт сүлд
- Хаад хаадын зарлигыг
- Хаслаж татсан зангидсан өнгөт сүлд
- Хамгийг хураах эрхшээлийг
- Хатлаж оньсолсон өнгөт сүлд
- Хамаг Монголын заяаг
- Хамгаалж гэрэлтсэн өнгөт сүлд
- Хасбуу алтан тамгыг
- Хурааж хүчжүүлсэн өнгөт сүлд
- Хүмүүн төрлөхтний оршинолыг
- Хүй зангидаж холбосон өнгөт сүлд
- Хүчирхэг төрийн эвийг
- Хашиж нэгтгэсэн өнгөт сүлд
- Хараа өндөр туганд
- Хойморлож залсан өнгөт сүлд
- Хөх төрийн бошгийг
- Хүндлэж оршоосон өнгөт сүлд
- Хүй төрийн гагнааг
- Хэлхэж гагнасан өнгөт сүлд
- Хүннү гүрний сүрийг
- Хүрэн зээрдээр тодлосон өнгөт сүлд
- Хүчит шонхорын дэвэлтийг
- Хараан өндөрт сүлдэлсэн өнгөт сүлд
- Домогт өвгөдийн эрдмийг
- Долгисуулж эрчлүүлсэн өнгөт сүлд
- Дайт эрсийн зоригыг
- Дуулал өргөж амилуулсан өнгөт сүлд
- Дуун ерөөлт хатдын
- Домогт алдрыг тунхагласан өнгөт сүлд
- Дээд оюут буурлуудыг
- Дундраш үгүй билгийг эрчилсэн өнгөт сүлд
- Аюутугайт зарлигаар
- Адислаж өргөсөн өнгөт сүлд



Алтан туганд
Айлж залагдсан өнгөт сүлд

6.1. ГАЛ ДҮРСЛЭЛ


Өнгийн галуудыг эвлүүлж бадарсан
Өнө мөнхийг бэлэгдэн цахисан
Өндөр Тэнгэрийн нараас эрчилж
Өндөр гарвалын цөм хүчийг
Өртөөлж гагнасан ариун гал болой.

6.2. НАР, САРАН ДҮРСЛЭЛ

Эртээ өвгийн нар саран холбоосыг
Эвлэж зангидсан саруул дээд ухаан
Саатаж ирсэн мөнх дээд язгуурыг
Эвлүүлэн соёмбо болсу.

6.3. ДӨРВӨН ТӨРИЙН НӨГДСӨН ХҮЧНИЙ ТЭМДЭГТ

Дүрээ үзүүлсэн дөрвөн хаант төрийн
Дүүрэн хүчийг зангидаж татсан
Дүүлэх Шонхорын эд хавыг
Дээдлэж шүтээндээ залсан
Дархан төрийн баганыг түшилцсэн
Даяар дуурсагдах далай даян хаадын
Догшин сүрийг нэгтгэж гэрэлтсэн хүч буюу



6.4. ТЭНГЭР, ГАЗРЫН СУДРЫН ТЭМДЭГТ

Хатуугаа хатуу Тэнгэрийн төрийн бодлого
Харанхуйг давах оюу билигт эрдмийн бодлого
Хайр ивээлийг түмэнд дүүргэх эрхэм бодлого
Халуун зүрхнийхээ чанад оршихуйд
Итгэлийг бат оршоох далд бодлого
Тэнгэр, газрын судрын их сүлэл энд оршино.

6.5. АРГА БИЛИГ ДҮРСЛЭЛИЙН НУУЦ

Амин судалт эр, эмийн эвийн чанар
Амь татсан газар, тэнгэрийн язгуур эс
Алтан урагт гэрэлтэн бойжих үрс
Агууг бүтээх Тэнгэрийн өгөгдөл болой.

6.6. УДМУУДЫН ТЭМДЭГТ БАГАНА ДҮРСЛЭЛ

Тэмдэгтээр бүтэж тэгш дүүрсэн
Төвөө хамгаалж гэрэлтэж сүндэрлэсэн
Газар Тэнгэрийг эвлэн зангидсан
Гарвалт хаадын алтан багана
Удам удмуудын хүч оршоосон
Ухаант хатадын дуулал оршоосон
Хөх төрийн тулгуур багана

Хүй төрийн хүчит багана болой.

7.1. “СЭРСЭН МОНГОЛ” УХАМСАР СЭРЭЛТИЙН ХУВЬСГАЛ

7.1. ХӨХ ОРШИХУЙДАА СЭРСЭН.

Сэтгэл тэнийх хөх оршихуй даа

Цэвэр билэгтэй удам болж төрсөн дөө бид бахдана

Цээж баяссан хөх эх униарыг хараад

Хөндий дүүрсэн талаа харан бид бахдана

Үүлийн холбоостой ертөнцийн аялгуугаар

Удам тосох хөх галаан бадраан бид бахдана

Хүмүүн тавилангийн язгуурын холбоосон дээр

Хүсэлт тэмүүлэл болсон энэ амьдралд

Хүмүүн болж төрсөн дөө бид бас бахдана

Эгшигтэй сайхан аялгууг бид дотроо бүтээж энэрэл урлаад

Эвээлтэй сайхан ертөнцөөс бид хүч авч эрдэм дүүргээд

Эрхэм сайхан тал оршихуй даа бид мэндэлж тухлаад

Энгийн нэгэн хүн болж бид ертөнцөд мэндэлсэндээ бас талархана

Заагдсан замаар бид аялаад

Зол ерөөлийг бид тавилан болгон атгаад

Зорьсон эх судраа бид хүртэнхэн баясаад

Зол гэрлээ бид өвөртөө дүүргэж хүмүүн болсондоо бид бахдана

7.2. ХӨХ ТӨРИЙН ТӨЛӨӨ СЭРСЭН

Хөх оршихуйгаа гартаа барьж бид сэрсэн юм

Хөрстийн амьдрал дээр тавилангаа барьж бид сэрсэн юм

Манхан тэнгэрт заяа тоссон удамдаа бид сэрсэн юм

Золголдон учиглах үйлийн холбоосонд бид эзэн болж сэрсэн юм

Эрдэнийн сав өргөөндөө бид оюу тэлж сэрсэн юм

Эрхэмсэж заларсан орчлонгийн сав оршихуйд бид гал атгаж би сэрсэн юм

Хөх нүүдэл сэрэв.

Хөндийд тухлах хөх оршихуй сэрэв.

Хүмүүн дүүрсэн удмын хөх мандал сэрэв.

Хүсэл тэмүүлэлтэй хөх анирлан төр энэхэнд сэрэв.

7.3. ХӨХ ТОЛБОНДОО СЭРСЭН.

Эрдмийн орондоо бид сэргэж өндийнө

Саатаж ирсэн цаг хугацаанд бид

Сарниж алсарсан бодлын холбоосыг бид

Зангидан байж сэргэж өндийнө

Угтаж ирсэн ураг түмнээ бид

Ухаан бодлынх нь тэгш оршихуйг нь

Дэлгэн залах зам оршихуйг нь бид таниулан байж сэргэж өндийнө

Уухай өргөж ухаанаа тодолсон түмэн ард минь

Учигтайхан оршихуйд нь биднийг илгээсэн хэмээн сэргэж өндийнө

Тэгшхэн дүүрсэн гал мандалтай өргөө гэрэндээ

Тэнхээ угтам ариун гэрлэн дээр эрдэм тосож сэргэж өндийнө

7.4. ХӨХ ЯЗГУУРТАА СЭРСЭН.

Удам тэмдэгтээ задлаж ураг болж сууг
Ухаан билигтэй Монгол хүн болж сэрж өндийж тухалаг
Түмэн язгуурууд минь сэрж өндий
Түвшин сайхан үрсийнхээ гал дээр дэлгэрч
Түнэр харанхуйд суусан үрс бид нар мэлмий нээж сэрж өндийе.
Мөнх цагийн холбоосоо бид батжиж билэг оюунаар нэгдэн сэрж тухалья
Эвэлсэн судлын холбоосонд бид эзэн больё
Энгэр дүүрсэн галанд бид хүч больё
Эрхэм сайхан сургаалийг бид дэлгэр дүүргэе
Эвээлт амьдралын холбоосонд би гагнаа үүсгье

7.5. ӨНГӨТ СҮЛДЭНДЭЭ СЭРСЭН.

Хаант төрийн сүлд ирэв
Хаант төрийн сүлд сэрэв
Хатан гуа дэлгэрэв дүүрэв
Үрс минь хөх оршихуй даа сэр
Үйлээ тодолж эрдэм оюудаа сэр
Эвээлтээ оршихуйд гал тосож сэр
Эрхэм газраа удмаа тодолж сэр
Учиглах тавилангийн оюу орон зайд
Орчлонгоо таньж сэр
Цаг хугацааны хэмийг эвлүүлэн сэр.

7.6. ХӨХ НҮҮДЭЛДЭЭ СЭРСЭН.

Оршихуйн хөх нүүдэл хийж Монгол сэрэв.
Огторгуйн хөх нүүдэл хийж Монгол сэрэв.
Сэтгэлийн хөх нүүдэл хийж Монгол сэрэв.
Тэнгэрийн хөх нүүдэл хийж Монгол сэрэв.
Хөх төрийг бадраах үрс болж сэрэв.
Хөх түмнээ сэрээх жим болж сэрэв.
Хөх гэрлийг түгээх хүч болж сэрэв.
Хөх амьдралын холбоос болж Энэ цагт Монгол сэрэв ээ
Түүчээлж урд нь алхья.
Түмнээ уухайлж урд нь тухалья.
Заагдсан газар зам татуулья
Заяагдсан оронд нь сэнтий тавья

8. СӨРСӨН МОНГОЛ ШУДАРГУУН ЁСНЫ ХУВЬСГАЛ

8.1. АВЛИГАЧДААС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Авлигачдаас салах бодлогын хувьсгал хийнэ. Албан тушаалтан, авлигачидтай тэмцэхэд шинэчлэл хийнэ. Тусгай чиг үүргийн бүтэц байгуулна. Нам-улс төр-бизнес-нам гэсэн гамшигт харилцааг таслан зогсооно. Цөөнх нь хөрөнгөжиж, олонхи нь ядуурдаг байдлыг халж, иргэн бүрийг баяжихад саад хийхгүй ч буруу баяжвал өршөөхгүй гэсэн шударга ёсны зарчмыг хэрэгжүүлнэ.

8.2. АРХИНААС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Архинаас салах бодлогын хувьсгалыг хийнэ. Архи үйлдвэрлэх зөвшөөрлүүдийг цэгцэлнэ. Экспортын баримжаатай болоход нь дэмжинэ. Архины борлуулалтыг хумина.

8.3. АНАРХИСТУУДААС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Анахристуудаас салах бодлогын хувьсгал хийнэ. Ардчилалын нөлөөгөөр бий болсон хэт дураараа аашлах үйлдлийг сахилгажуулна. Гадны бодлогоор төрийн бус байгууллага, сангаар дамжуулан хүүхэд залуучуудад сөрөг нөлөөлөл үзүүлж буй үйл ажиллагааг таслан зогсооно.

8.4. АЖИЛГҮЙДЛЭЭС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ


Ажилгүйдлээс салах бодлогын хувьсгал хийнэ. Үндэсний үйлдвэрүүдийг хөгжүүлэх замаар сална.

8.5. АБОРТЫГ ТАСЛАН ЗОГСООХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Абортыг таслан зогсоох бодлогын хувьсгал хийнэ. 33 жилд сая гаран хүний амиар тоглосон хуулийг өөрчилнө. Үр хөндөлтийг хориглох хууль гаргана.

8.6. АМИНЧ ҮЗЛЭЭС САЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Аминч үзлээс салах бодлогын хувьсгал хийнэ. Нийтээрээ сайхан амьдрах зорилго бүхий хамтын ардчилал, хамтын зах зээлийн эдийн засгийг хөгжүүлнэ. Үндэстэнээрээ нэгэн зүгт харж хөгжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.



9. СУУЦТАЙ МОНГОЛ АХУЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

9.1. ХОТУУДЫН ДЭД БҮТЭЦИЙН СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ

Баруун бүс, Зүүн бүс, Хангайн бүс, Говийн бүсийн шинэ хот төлөвлөлтийн төлөвлөгөөг боловсруулж, зам тээвэр, инженерийн дэд бүтэцийг байгуулах ажлыг эхлүүлнэ. 2027 оноос бүсийн хотуудыг байгуулах суурийг тавина.

9.2. ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН БОДЛОГЫН ӨӨРЛӨЛТ

Суурин газрууд болон шинэ хотын төлөвлөлтөнд уламжлалт хэв маягыг шинээсэн барилга байгууламж, сууршлийн барилгуудыг стандартыг тогтоож хэрэгжүүлнэ.

9.3. УЛАМЖЛАЛТ ГЭРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГО

Монгол гэрийг суурьшимал хэв маягт тохируулан шинэчлэх санаачлагыг дэмжинэ. Төр хувийн хэвшлийн хамтын хүчээр нүүрс түлэхгүйгээр тав тухтай амьдрах таатай нөхцлийг бодлогоор дэмжинэ. Энэ чиглэлийн үйлвэрлэл эрхлэгч, санаачлагч нарыг төрөөс бодлогоор дэмжинэ.

9.4. ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ОРОН СУУЦЖУУЛАХ ХӨТӨЛБӨРТ БОДЛОГО

Залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөрийг шинэчлэх бодлого хэрэгжүүлнэ. Монгол залуу гэр бүлийн 20 жилийн хөдөлмөрийн хөлсийг 2-хон өрөө байранд төлж, банкны эзэнд хөдөлмөрөө өгөхийг, 100 сая төгрөгийн зээлийг 250 сая болгож банкны эзэнг баяжуулахыг таслан зогсооно. Монгол эх орныхоо төлөө ухаан бодлоо чилээх боломжийг олгоно. Монгол эх орныхоо төлөө ухаан бодлоо чилээх боломжийг олгоно. Монгол улсын иргэн 21 нас хүрсэн үед орон сууцтай болох, бие даах чадварыг төрийн зүгээс дэмждэг байх санал санаачлага гаргана.

9.5. АХУЙН ШИНЭ (МИНИМАЛИСТ) ХЭВ ЗАГВАРЫН ХУВЬСАЛЫН БОДЛОГО

Залуу хүмүүсийг байрны төлөө амьдардаг биш Монгол үндэстний төлөө зүтгүүлэх боломжийг нээнэ. Зах зээлийн эдийн засагтай Сингапур, Норвеги зэрэг орны үнэ төлбөргүй орон сууцжуулах шилдэг туршлагыг үндэслэн үйлдвэрчний эвлэлтэй бүх талаар хамтран ажиллаж, үндэстний хөрөнгө оруулалтын сангуудын орлогын тодорхой хувь хэмжээг орон сууцтай болгох боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгоно. Үндэстний хэмжээнд минималист хэв маягын үндэстний хөтөлбөр хэрэгжүүлнэ.

9.6. СУУЦТАЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТӨРИЙН БОДЛОГО

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн хамгаалалтанд авч энгийн хүн шиг амьдрах бололцоог бүрдүүлж орон сууцны тусгай бодлогоор дэмжинэ

10. СЭРЭМЖТЭЙ МОНГОЛ ҮНДЭСНИЙ СОРИЛТЫГ ЖАМЫН ХУВЬСАЛ

10.1. БАЙГАЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ УСНЫ АЮУЛЫГ ДАВАХ БОДЛОГО

Хавар, зун, намрын улиралын уснаас үүдэх аюулыг гэтлэх улс даяарх ажлыг зохион байгуулна. Үер усны голдролын дагуулах хот суурин, малчин айлуудыг нүүлгэх шилжүүлэх, анхаруулах ажлыг зохион байгуулна. Урьдчилан хамгаалах ажлыг зохион байгуулна.

10.2. БАЙГАЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ ГАЗАР ХӨДЛӨЛТ, ГАЛЫН АЮУЛЫГ ДАВАХ БОДЛОГО

Газар хөдлөх аюулыг гэтлэх үндэсний хэмжээний аюулыг хамтаараа даван гарна. Үүнээс үүдэн гарах галын аюулыг сэргийлэх техник хэрэгсэл, хүн хүчийг шуурхайлан бэлтгэнэ. Орон нутгийн зам, хот суурингийн хязгааралтыг урьдчилан хэрэгжүүлнэ.

10.3. БАЙГАЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ ЗУД, ШУУРГЫН АЮУЛЫГ ДАВАХ БОДЛОГО

Цагаан гамшигийг давах үндэсний төлөвлөгөө хэрэгжүүлнэ. Малын тэжээл, өвсний нөөцийг үндэсний хэмжээнд зохион байгуулна.

10.4. ДОТООД БИЛГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ СЭТГЭЛИЙН СОРИЛТЫГ ДАВАХ БОДЛОГО

Алтан галав нь хүний зүрх сэтгэлд өрөн буй тул удам өвөг буурлуудтай холбогдон замчуулж, тогтуун тайванаар, толч төвчөөр давах сургалт, чигүүлэлтийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ.

Сэтгэлийн сорилтыг давах үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлнэ.

10.5. ДОТООД БИЛГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ УХАМСАРЫН СОРИЛТЫГ ДАВАХ БОДЛОГО

Ухамсарт хүмүүн болох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Ухамсар нь хүний дотоод ертөнцийг гэрэлтүүлэх сэрж ухаарах жим болно.

10.6. БОДЬГАЛ БИЕТ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ДАВАХ БОДЛОГО

Махан биет хүмүүсийн биеийн зовлонг туулах хатамжит сорилтыг давах чухал. Бие бэлдээгүй нь шүүлтэнд орж, биеэ бэлдсэн нэгэн нь шинэ хэмжээст шилжилтэнд орно. Биеийг ариун байлгах нь жамын хууль болой.

11. СУРТАХУУНТАЙ МОНГОЛ ТӨЛӨВШИЛИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

11.1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХДИЙН ТӨЛӨВШИЛИЙН БОДЛОГО

Монгол хүүхдэд тохирсон монгол хүн үзлийг багаас нь суулгана.

Ёс суртахуунт иргэнийг төлөвшүүлэх ажлыг сургуулийн өмнөх боловсролоор дамжуулан багаас бэлтгэх бодлого барина.

Иргэний эрхийг үүргийн хамт, чөлөөт байдлыг сахилга батын хамт, эрх чөлөөг ёс суртахууны хамт төлөвшүүлэх бодлого барина.

Удмын хэлхээт хариуцлагын тогтолцоог сэргээж удмаар дамжин төрт ёсыг эмхэлдэг ёс суртахуунт иргэнийг төлөвшүүлнэ.

Монгол хүүхдийг тоглох газаргүй, хүмүүжих орчингүй, зөнгөөрөө өсөхийг, ерөнд баригдсан ирээдүйтэй байхыг өөрчилнө.

Монгол хүүхдийг Монголын ирээдүй хэмээн хүндэтгэж, Монгол хүүхдэд тохирсон Монгол гэсэн сэтгэлгээг хөгжүүлэх залгамж үеийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Монгол хүүхдийг хэвлийд байхаас нь төрийн хамгаалалтанд авч, Монгол ухаанаараа хүмүүжүүлэх шалгарсан аргуудыг хэрэгжүүлэн хэвшүүлэх, эрүүл саруул Монгол хүн болон хүмүүжих, боловсрох үндсэн суурийг бий болгож анхаарч ажиллана.

Монгол хүүхэд бол Монгол үндэстний ирээдүй учир хайрлаж, хамгаалж өсгөх ёстой. Ирээдүйд Монгол улсаа авч явах боловсон хүчин учраас хамгийн орчин үеийн мэдлэг боловсрол эзэмшихэд шаардлагатай суурь мэдлэгүүдийг бүгдийг нь эзэмшүүлж, өндөр ёс суртахуунтай хүн болгон төлөвшүүлэхэд анхаарах болно.

Монгол хүүхдэд зориулсан багаас нь хүмүүжил, иргэний боловсрол олгох “ЭЗЭН ХҮН 78/22” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж Монголын ирээдүйг багаас нь хөгжүүлнэ.

11.2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХЭД ТӨЛӨВШҮҮЛЭХ БОДЛОГО

Боловсролын хөтөлбөр тогтолцоог туршилтын талбар болгохыг нэн даруй зогсоож, үндэсний эрдэмтэн мэргэд, багш сурган хүмүүжүүлэгч нарын хүчээр үндэсний онцлогийг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулна. Боловсролын хөтөлбөр нь сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах сургуулийн боловсрол, мэргэжлийн, тусгай, дээд боловсролын зэрэг бүх салбар шатлалыг хамарсан шинжлэх ухаанч, цогц бодлого байна.

11.3. ЗАЛУУЧУУДУУДЫГ ӨӨРИЙГ УДИРДАН ЗАСАХУЙН ТӨЛӨВШЛИЙН БОДЛОГО

Дэлхийг харж, сэтгэдэг хүмүүсийг тусгай сургалтаар дамжуулан бэлтгэнэ. Монголын ирээдүйн залуусыг дэлхийн хэмжээний бодлого боловсруулах чадвартай шинэ үеийн ёс суртахуунтай боловсон хүчинг бэлтгэнэ.

Монгол оюутнуудыг Монгол үндэстний ирээдүйг авч явах учир өндөр ёс суртахуунтай, боловсон хүчин болгон бэлтгэхэд нийгмийн бодлого чиглэгдэнэ. Залуучуудын мэдлэг боловсрол эзэмшихээр сурч буйг ариун хөдөлмөрт тооцох ёстой. Улс, үндэстэн, эх орныхоо төлөө мэдлэг эзэмшин түүнийгээ эх орныхоо гэрэлт ирээдүйд зориулахаар суралцаж байгаа учраас хөдөлмөрлөж байгаад тооцох ёстой.

Даяарчлагдсан ирээдүйд Монголын залуучуудад зориулсан нийгмийн бодлогын нэг гол хэсэг нь тэтгэлэг байх болно. Монгол залуу хүний суралцах боломжийг төрөөс дэмжих, гаргасан зардалд тэтгэлэг олгодог байх эрх зүйн орчиныг бүрдүүлнэ.

Их дээд сургуулиудыг орчин үеийн технологиор хийсэн эрдэм шинжилгээ, судалгааны иж бүрэнлаборатори, хамгийн багадаа 5 сая номтой

номын сантай, багш оюутны амьдрах байртай сурах бүх бололцоог цогцоор нь шийдсэн хотхон хэлбэрт оруулах болно.

Оюу билигт оюутны сургалтын төлбөрийг нь үнэ төлбөргүй болгоно. Монгол оюутныг тусгай зорилго өвөртлүүлэн гадаадын их, дээд сургуульд сургаж, бэлтгэх замаар мэдлэгт суурилсан дэлхийг угтан хөгжих үйлдвэрлэлүүдийг хөгжүүлэх боловсон хүчнээ бэлдэнэ. /72 /22 хөтөлбөрөөс харах/

11.4. НИЙХЭМЭЭР АМЬДРАХ НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНЫ БОДЛОГО

Монгол залуусыг Монголыг дахин хүчирхэгжүүлэхэд зүтгэх хүч хэмээн хүндэтгэж, тэднийг гадаадын нэр хүнд бүхий 100 их сургуулиуд, нарийн мэргэжлийн сургуулиудад төрийн 100 хувийн зардлаар тодорхой зорилго, тусгай гэрээний дагуу бэлтгэх, чадваржуулах, мэдлэгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Ерөнхийлөгчийн илгээлт 2100 тэтэглэгт хөтөлбөрийн хүрээнд/. Тэднийг шинэ физик, шинэ биологи, шинэ математик, шинэ хими, шинэ сансар судлал, инженерчлэл, шинэ химийн инженерчлэл, шинэ механик инженерчлэл, шинэ электроникийн инженерчлэл, шинэ цахилгааны инженерчлэл, шинэ материалын инженерчлэл, шинэ сансрын инженерчлэл, шинэ биоинженерчлэл, шинэ наноинженерчлэл гэсэн нарийн мэргэжлүүдээр мэргэшүүлэн бэлтгэнэ. Мөн санхүүгийн, маркетингийн, менежментийн, борлуулалтын, хүний нөөцийн, мөнгөний, олон улсын капиталын зах зээл, философи, хэлний философи, оюуны философи, улс төрийн философи, эдийн засгийн философи, этикийн философи, шинжлэх ухааны философи, метафизикийн философи, хуулийн философи, улс төрийн шинжлэх ухаан, социологийн шинжлэх ухаан, хуулийн шинжлэх ухаан гэх мэт холч хараатай бодлогоор боловсон хүчнээ зохион байгуулалтайгаар бэлтгэнэ.

11.5. УХАМСАРЛАН ХӨГЖИХҮЙН ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ БОДЛОГО

Өөрийгөө нээн олж, удам өвгөдөөсөө тусгай үйл хэрэг тээж төрсөн хүмүүсийг сэргээн өндийж, ёс суртахуунлаг иргэн бий болоход дэмжинэ.

11.6. БИЛИГ ЭРДЭМД СУРАЛЦАХҮЙН ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ХӨТӨЛБӨР

Монгол Үндэстний нэгдэн нягтрах Монгол бодлогыг эрчимтэйгээр явуулж, Монгол хүн бүрийг Монгол нутагтаа эргэн ирэх, иргэнших, амьдарч, ажиллах боломжийг Монгол төрийн олуулаа болох бодлогоор хэрэгжүүлнэ.

Монгол хүмүүсийн хамтран оюун санаагаа нэгтгэх, мэдлэгээ хуваалцах, хамтран үндэсний болон үндэстэн дамнасан байгууллагууд байгуулахыг хөхүүлэн дэмжинэ.

12. СҮРЭГТЭЙ МОНГОЛ НҮҮДЭЛЧДИЙН ӨВИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

12.1. МАЛЧИД, ТАРИАЛАНЧДЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ӨСГӨНӨ.

Хүн төрөлхтний хүнсний 80 хувь нь мал аж ахуйгаас гаралтай, мал аж ахуй нь газар тариалангаас 20 хувийн ашигтай байдгаас гадна олон наст таримал бэлчээртэй мал аж ахуйн бүтээмж нь өндөр байдаг.

Хосолсон хэлбэрт бэлчээрт тулгуурласан мал аж ахуйгаар хөдөө аж ахуйн хөгжлийн гол чиг хандлага болгож, Монголын өрх бүр өөрийн таримал бэлчээрийн мал аж ахуйтай байхыг хуульчлан тогтоож төрийн хамгаалалтанд авна.

12.2. НҮҮДЭЛЧДИЙН ӨВ СОЁЛ ХАМГААЛАХ БОДЛОГО

Нүүдэлдчийн ахуйн өв соёлыг хамгаалах бодлогын Улсын их хурлаар батлуулж үндэсний дархлааны хууль батлуулна. Нүүдэлч ахуйд шингэсэн уламлат занзаншилыг дэлхийд түгээн дэлгэрүүлэх бодлогыг дэмжинэ.

12.3. ТАВАН ХОШУУ МАЛЫН ХҮНС, ТЭМЖЭЭЛИЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ

Угтан ирж буй гамшигт үзэгдлийг давахын тулд малын тэмжээлийн нөөцийг орон даяар хэрэгжүүлнэ.

Малын импортын өвс, тэжээлийг нөөцийг 3 жилээр төлөвлөн нөөцлөх төрийн бодлого баримтлана.

Малчдын өвөлжилтын бэлтгэлийг хангах ажлыг улсын хэмжээнд хөтөлбөр хэлбэрээр зохион байгуулна.

12.4. МАЛЧДЫН ХОРШИЛТЫГ ДЭМЖИХ БОДЛОГО

Өвлийн улиралд байгалийн бэрхшээлийг давах хот айлсалт, хамтаараа гэтлэн гарах нэгдлийг хөхиүлэн дэмжих, төрөөс бодлогоор дэмжинэ.

12.5. ХОСОЛСОН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Цэвэр газар тариалангийн салбар нь эдийн засгийн хувьд тарималжсан бэлчээртэй мал аж ахуйгаас хорин хувиар бага байдаг гэдгийг олон улсын түвшинд баталсан бөгөөд Евроазийн бүс нутаг нь экологийн хувьд хэврэг учраас цэвэр газар тариалан эрхлэх нь цөлжилт элсжилтийг сүйрлийн хэмжээнд хүргэх аюултай тул Монгол улс дээрх хүчин зүйлээс үүдэж таримал бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлж тариалантай хослуулах.


12.6. ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУЛГУУРЛАСАН ҮЙЛДВЭРҮҮДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Малын түүхий боловсруулах үйлдвэрүүдийг төрөөс бодлогоор дэмжинэ. Хувийн хэвшлийн хамтарсан түншлэлийг хөгжүүлнэ. Малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэтгэвэрт хамрагдах бололцоог хангах, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжэй болгоно.

13. “СУУТ МОНГОЛ” ЯЗГУУР ХААДЫН ТӨРИЙН ЗАРЛИГУУДААС
(2024 онд буулгасан язгуурын хаадын зарлигуудаас дээжлэн оруулав.)

13.1. ДУВА МЭРГЭН ТЭНГЭРИЙН ХААНЫ ЗАРЛИГААС

Дуулалт их өндөрөөс Дува мэргэн би бээр
Даяан Монгол түмэнд зарлиг болруун
Хөх эрин эхэлснийг дуулгасу
Хөх толботны гэрээг
Хөрстийг амгаланжуулах зарлиг дор
Хүй төрийг урлах эрх дор
Хамгийг засаглах гэрэгэгээ авсу
Хаадын хаадын хааны эрхшээлээр
Хас тамгат хөх төрийг
Хүмүүний ертөнцийн жаманд уялдуулж
Хуралдайн шийдвэрээр зарлиг тоссу
Хаант төрийн Тэнгэрийн бодлогыг
Хүчирхэг төрүүдийн сүлдэнд хураасу
Хүй төрийн алтан туганд
Өнгөт соёмбыг оршоон залсу
Даяар суу билгээрээ гэрэлтэгч
Далдын эрдэмт хөх Монгол сэрсү...
...Дайчин удамт хөх толботонгууд
Дүүлэх харцага шонхор лугаа оршсу
Дээд Тэнгэрийн зарлигтан хэмээн
Дэлхийн дайтад сэтгэн өндийсү...
...Түүх давтагдах бичээс
Тэнгэрээс буудаг гэдгийг өчсү
Түнэр харанхуйг чинь үргээж өгөх
Тэнгэрийн зарлиг ирснийг дуулгасу
Эв зөийн дор
Эрхэт оддын дор
Ивээлт газрын дээр
Эх дэлхийн амгаланг
Эгнэгт Эзэн Монгол тогтоож
Эмх цэгцтэй засаглаж байсныг санату
Ирээдүй хүртэл ижил гэдэгт
Итгэл найдвараа өгсү...




13.2. ДОБУ МЭРГЭН ТЭНГЭРИЙН ХААНЫ ЗАРЛИГААС

Хөх Мөнх тэнгэрийн орноос
Хүмүүн төрөлхтөн та бүгдэд
Хөвөөлөн хөвөөлөн сэнтийлэх
Их хаадын өргөөнөөс
Хүндэт их үйлийн зангилаа болгон
Энэхүү зарлигийг буулгасу...
...Хаант төрийн хатуу судрыг
Хамаг түмэнд дуулал болгон өргөсү
Халуун зүрхтэний эвийн их зангилаанд
Хүй төрийн гурван цагийг хэлхсү...
...Даяар түмний хөх очист сэтгэлд
Хөх нүүдэл эхэлснийг санату...
...Холын хараат Тэнгэрийн бодлого
Хаант төрийн бошгот бичээс болон
Хорвоогийн айд мутарлагдсаныг санату

Хүмүүнийг цэгцлэх Тэнгэрийн зарлиг
Хөх эринтэй тухалсны дуулгасу
Энэрлийг оршоосон шударгуун төр
Энхийг тунхаглах амгалан төр
Эвийг уухайлсан ариун төр
Эрчлэлийг оршоосон их төр
Этүгэнд тухлаж Эх язгуураараа сэрснийг тунхагласу
Эв бүхэн хүч болсу
Энх цаг ирсү...

13.3. ХҮННҮ ГҮРНИЙ ИХ ШАНЬЮ ТҮМЭН ШАНЬЮГИЙН ЗАРЛИГААС

Хүннү гүрний Их Шанью Түмэн би бээр хөрстийн үрсэд зарлиг болруун
Хээнцэр гоо Хүннү төрийн
Хүчит судар оньст үүдээ нээж
Хуй мэт эсгэрэн эргэлдэх
Хүчит Шанью нар оюу билигээр түүчээлж
Хаант төрийн сүлдээ өргөх
Хамгийг нэгтгэх их эвд нэгдснийг дуулгасу...
...Их хэнгэрэгэн дэлдсү
Их бүрээгээн татсу.
Их уухайгаа өргөсү.
Их сүлдээ мандуулсу...
... Хүлээн суугаа түмэн олны
Хүлээсийг нь тайлж чөлөөлсү.
Дөнгөнд баригдсан түмний үрсийг
Дотроос нь гэрэлтүүлж аварсү.
Дээд оюутын суу эрдмийг
Дэлхийн дайтад цацсу...
...Суут хаадын хасбу тамга
Сударт зарлигд дарагдсу.
Эрхэт Тэнгэрийн орноос
Эрхшээлт хаад зарлиг буулгав...
...Эх язгууртаа сүслэсү
Эцэг Тэнгэртээ мөргөсү.
Аюутугай.




13.4. СЯНЬБИ ГҮРНИЙГ ИХ ХААН ТАНЬШИХУАЙ ХААНЫ ЗАРЛИГААС

Түмэн олоно нүүдэлчин удмын үрсдээ зарлиг болруун
Түүхт Хүннү гүрнийг залгамжлагч
Тунгалаг үйл үргэлжүүлэгч
Төрийн ёсыг цогцлоогч Таньшихуай би бээр
Талын нүүдэлчин гүрнийг эмхлэн байгуулсан
Тэнгэрийн тамгат хаан билээ.
...Оюу билигт хөх өвгөдийн удам
Огтоно зурам шиг амьдарч үл болно.
Тэнгэр язгуурт дээдэсийн үрс
Тэнэгийн мунхагт автаж үл болно. Мэдсү...
...Чин шударгуун дор л төр босдог.
Цэх үнэн дор л төр манддаг
Оюу билгийн хүчинд л төр цэгцэрлдэг.
Хатуу цаазан дор л төр сахилгаждаг.
Мэргэн түшмэлийн ухаан л төр төвширдөг.
Төрийг урлая хэмээвээс

Чанад дэглэмийг хаанаас эхлээд
Харц хүртэл ямхын алдаагүй дагасу.
Төр төвшрөх болтугай.

13.5. ИХ НИРУН ГҮРНИЙ ИХ ХААН МУГУЛЮЙ ХААНЫ ЗАРЛИГААС

Нирун төрийг үндэслэгч Южиулюй Мугулюй хаан би бээр
Нүүдэлчин засгийн үрсдээ зарлиг болруун
Нүүдэлч түмнээ нэгтгэж
Тэнгэрийн эрхийг атгасан удаатай
Нуман зэвсэгт түмнээ эмхэлж
Нүүдлийн засаглалыг тогтоосон удаатай
Өнчин хөвгүүнээс
Өндөр бошгит хаан болтлоо
Өршөөл, өс, өргөмжлөл дунд хэрсүүжин боссон шашдирыг минь мэдсү...
...Их төрийг эвлэн босгохдоо
Ирт сэлэмний хүчин дор
Их цаазат зарлигаар зангидсаныг мэдсү
Урвагчийг угтаж цаазалсу
Шарваачийг тосож цаазалсу
Үнэнчийг өргөмжилж томилсу
Чин шударгууныг дээдэлж залсу
Мэргэнийг хүндлэн тохоосу
Чингэвээс чин шударгуунаар түрэн саруулжиж
Цэх түшмэлүүд үйлээ мэддэгийг дагасу...
...Хүмүүний ертөнцийг эрхшээх
Хаант төр өндийсү
Хамаг бүгдээр мөр өсү
Халуун зүрхтэн нэгдсү
Хар сүлдэнд биширсү
Хас тамга эрчлэгдсү
Хаан төрийг тунхагласу
Хайр энэрэл дэлгэрсү
Хаадын зарлиг түгсү
Ашдын амгалан тогтох болтугай.




13.6. ХӨХ ТҮРЭГ ГҮРНИЙ ХААН БУМАН ХААНЫ ЗАРЛИГААС

Хөх Түрэг Улсыг үндэслэн дэлүүн өндөр Буман Хаан би бээр зарлиг болруун
Талын түмний их уухайн дунд
Тарсан нүүдэлчидээ эвлүүлэн зангидаж
Түүх төгөлдөр Хүннү дээдсийн ариун галыг
Тивийн дунд зангидан бадрааж
Түрэг гүрнийхээ суурийг тавьсан
Төгс төгөлдрийн төрийг бэхжүүлсэн удаатай...
...Хөх тамга тодрон амилж
Хүний жамыг ухаардгыг санату
Дүүрэн Монгол өндийж
Хуйт салхи лугаа эрчлэгддэгийг санату
Хөх эрдэмийг оройдоо залж
Хөвчин дэлхийг засдагыг санату
Хөх оюу билэгтэнгүүд
Хаан төрийг бүтээдгийг санату...
...Эрдэм үгүй харьд эрхээ юунд хянуулна

Эрхэт хаадын удам алтан сүлдээ юунд унуулна
Энэгүй эх түүхтэй алтан сүрээ юунд гундуулна
Эрт цагийн сүртэй атал сүнсээ юунд гомдооно.
Эрхэт тэнгэрээс харан байна
Эргэж байрандаа ирсү
Эцэг галаа бадраасу
Эзэн хаадаа таньсу...
Энх амгаланг хүсэж байвал
Эрдэм билэгт л шамдахыг хэлэх бусуу
Эрхшээлт төрийг урлъя хэмээвээс
Эх язгуураа сэрээх бусуу
Энэрэлт төрийг цогцлооё хэмээвээс
Эвийн зангилаа эрдэнэ бусуу
Аюутугай.
Эрхэт төр мандсуу.

13.7. УЙГАРЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ИХ ХААН КУТЛУК БИЛГЭ КУЛ ХААНЫ ЗАРЛИГААС

Уйгарын эзэнт гүрнийг урлан тунхаглаж
Улс гэрээн голомтот бууринд засаж
Ухаан мэргэдийн хэл соёлт, оюу төгс
Улс гүрнийг цогцлоож өндийлгөсөн
Их хаан би бээр замбуулинд морилон тухлаваа...
...Улс гүрнээ шинээр эмхлэх
Учиг утгат цагт тулжирснийг мэдсү
Устан буй төрийг ерөөл өргөн үдэж
Учран золгох оюу билигт төрөө
Угтан авч уухайт дуулал өргөсү...
...Гүрэн байсан атал
Гүрэвлийн дайтай бодлоготой болоо юу
Гүрэн байсан атал
Гүзээн чинээ сэтгэхүйтэй болоо юу
...Улс Монголоо засан босгож
Удам бүр цэгцрэн тэгширч
Өндөр Тэнгэрийн эрхшээл дор
Өнөд үргэлжлэх оюут төрийг тунхаглаж бүтээсү...
Аюутугай.




13.8. КИДАН ГҮРНИЙ ИХ ХААН АМБАГЯН ХААНЫ ЗАРЛИГААС

Тэнгэрийн ивээлт тамгат хаан би бээр
Төрт ёсыг цогцлоож
Түмэн түмэн олныг Кидан гүрэнд нэгтгэж
Түүх шаштираа урласан удаатай...
...Гүрэн улсын нууц нь
Тэнгэрийн санаа гэдгийг мэдсү.
Гүрэн улсын хүч нь эвийн зангилаа гэдгийг мэдсү.
Гүрэн улсын сүр нь хаан хүмүүний оюу билиг гэдгийг ойлгосу.
Гүрэн улсын сүлд нь
Тэнгэр, газрын эрчим гэдгийг хэлсү...
...Тэнгэрийн тоололт он цаг
Түүхийг хэлхэн гэрэлтүүлэх болтугай.
Түүчээлж өндийсөн тамгат үрс
Тивийг зангидан амгаланжуулах болтугай.
Төвд оршигч чин үндэстэн

Тэнгэрийн бодлогоор засаглах болтугай.
Аюутугай.
...Алтан хэлхээ үргэлжилсү.
Агуу хаад эрчлэгдсү.
Ард олон эвлэсү...

13.9. ИХ МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ХААН ЧИНГИС ХААНЫ ЗАРЛИГААС

Тив дэлхийн Тэнгэрийн их хаан Чингис би бээр
Түмэн олон үрсдээ зарлиг болруун
Хөх манхант Тэнгэрээс хөвөөлөн хөвөөлөн өртөөлсөөр
Хөрстийн энэхэн айд хүрч би ирэв
Хүн зон минь амгалан уу?
Хаант төрийн Уухайг өргөхөөр
Хас тамгаан атган би буулаа
Харанхуйн төрийг цэгцлэхээр
Хараа өндөр сүлдээ өргөхөөр
Хар сүлдээ гартаа атган
Хүй төрд хүч нэмэхээр
Хэнгэрэгт дуулалаа өргөж
Хөвчин дэлхийд морилсныг минь
Хүмүүн бүрт дуулган сонордуулсу
...Хатуугаас хатуу Тэнгэрийн цааз буулгаж
Хамаг Монголоо эмхэтгэе хэмээн бодов
Халгаат муу төрийн бодлогыг сольёе хэмээн бодов
Харанхуйн төрийг үдэж өгье хэмээн бодов...
...Үрс сонсту
Их Монголын хаадын хаан би бээр зарлиг болруун
Газар, усаар оролдогсодыг газрын гавд цөлсү
Гадны бодлогод автагсадыг гарвалт өвгөдөд нь мэдүүлсү
Түмнээр тоглогч түшээдийг удамт цаазад оруулсу
Түүхийн үнэнг гуйвуулагчийг төрийн цаазад оруулсу...
...Тарсан Монголоо хурааж
Туг сүлдэндээ эвлүүлсү
Тамгат үрсээ сэрээж
Төрийн үйлэнд мордуулсу
Тэнгэрийн их хаадын зарлигыг
Тэрслэл үгүй дагасу...
...Найман зууны дараа ирнэ гэсэндээ
Нартад би тухлав
Нармай Монгол бүхэнд тунхагласу
Найгаа алдах үед чинь
Нэгтгэн зангидахаар бууна гэсэндээ
Нэгэнтээ би өчсөн бус уу
Тэнгэрийн их хаан морилж гэж
Тив дэлхийд зарласу
...Ташуурт Монголын эрс
Тулаанд бэлэн жагссу
Таалалт хөх төр
Түүхт Монголд минь мандсу
Хаан төрийн өргөө үүдээ нээж
Хөх Мөнх Тэнгэрийн орноос Хаадын хаан би бээр зарлиг буулгав.
Аюутугай. Биширтүгэй.



ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД

Язгуурын төрийн бодлого баримтлагч Монгол Консерватив нам
Язгуурын төрийн бодлого баримтлагч Монгол Улсын Ерөнхийлөгч
Язгуурын төрийн бодлого баримтлагч Монгол Улсын Их Хурал,
Язгуурын төрийн бодлого баримтлагч Монгол Улсын засгийн газар
Хууль тогтоох байгууллага

Шүүхийн байгууллагууд

Язгуурын мэдлэгтэй, эрдэмтэй, эх оронч, хөдөлмөрч иргэн

Монгол гаралтай дэлхийгээр тархан суурьшсан оюунлаг эрдэмтэй хүмүүс

Дэлхийн соруудыг дайчлан ажиллуулж чадах оюунлаг удирдагчид


Монголын Үндэсний Консерватив үзэлтэй бүх хүмүүс

Үр ачдаа санаа зовиногч сэрсэн ахмадууд

Дэлхийн мэдлэгтэй сэрсэн залуучууд

Хатан ухаант сэрсэн эмэгтэйчүүд

Чин шударгуун иргэний оролцоо



ЯРУУ ЭГШИГЛЭНТ
ЯЗГУУРЫН ТӨРТ ЁС ТОГТОХ БОЛТУГАЙ
-----оОо-----

ТАЛАРХАЛ,

“Төрийн бодлогын хувьсгал 13С” мөрийн хөтөлбөрийг боловсруулахад мэдлэг чадвар, чин сэтгэлээ дайчилсан бүх хүмүүст талархал илэрхийлье.

Эдийн засагч

Монгол Консерватив намын дарга



Намжилын Дашдаваа

2024 оны 4 дугаар сарын 15-ны өдөр